# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 16 (445)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*
- *Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2006 оны дөрөвдүгээр сарын 28 | №16 (445)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 230. | Журам батлах тухай | Дугаар 51 | 425 |
| 231. | Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Дугаар 53 | 437 |
| 232. | Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай | Дугаар 54 | 440 |
| 233. | Тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 55 | 441 |
| 234. | Арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай | Дугаар 56 | 441 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ


| | | | |
|---|---|---|---|
| 235. | Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 2/04 | 460 |


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 3 дугаар сарын 22-ны өдөр** | **Дугаар 51** | **Улаанбаатар хот**

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмыг хавсралт ёсоор батлсугай.

2. Засгийн газрын агентлаг, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмыг баталж мөрдүүлэхийг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2002 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 161 дүгээр тогтоол, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 277 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАТБОЛД**

*Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолын хавсралт*

## ЯАМ БОЛОН АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ЖУРАМ

### 1. Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь яам, аймаг, нийслэлийн Засаг даргаас төр, засгийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан бодлогын зорилт болон Засаг даргаас Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн биелэлт, үйл ажиллагааны үр нөлөөг тогтоож, үр дүнг үнэлэхэд оршино.

### 2. Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилт

2.1. Бодлогын зорилтууд, түүний дотор хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд, Засгийн газрын шийдвэр, төсөл, төлөвлөгөө нь Засгийн газраас хүлээж байгаа үр дүнд хүрч хэрэгжиж байгаа эсэхийг тогтоох;

2.2 Яам, аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх;

2.3. Бодлогын зорилт хүлээгдэж байгаа үр дүнд хүрч хэрэгжээгүй буюу гажуудал гарсан бол тэдгээрийг өөрчлөн залруулах чиглэл, арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд бодлогын шинэ зорилтыг тодорхойлж Ерөнхий сайд, Танхимд танилцуулах;

2.4. Шийдвэр гаргах үйл ажиллагааг бодлогын хувилбар, санал дүгнэлт, зөвлөмжөөр дэмжихэд чиглэгдэнэ.

### 3. Хяналт шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ

3.1. Хяналт шинжилгээ, үнэлгээнд төрийн захиргааны төв, нутгийн захиргааны бүх шатны байгууллага хамрагдана;

3.2 Хяналт шинжилгээ, үнэлгээг яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тухайн жилийн үйл ажиллагаанд, эсхүл бодлогын тодорхой чиглэлээр хийнэ. Хамрах хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно;

3.3. Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх агентлаг, түүнчлэн сум, дүүргийн үйл ажиллагаанд хийх хяналт шинжилгээ, үнэлгээний журмыг Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно;

3.4. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жилд 6-гаас доошгүй яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд энэхүү журмын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газарт танилцуулна.

### 4. Хяналт шинжилгээ, үнэлгээний арга

4.1. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан гүйцэтгэнэ. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ холбогдох газруудтай хамтарсан хяналт шинжилгээ, үнэлгээний багийг байгуулан ажиллуулж болно;

4.2. Хяналт шинжилгээ, үнэлгээний ажилд холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, энэхүү журам болон удирдамжийг үндэс болгоно;

4.3. Яам, аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн үйл ажиллагаандаа хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг 4 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ;

4.4. Яамдын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг энэхүү журмын 1 дүгээр хавсралт, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийг журмын 2 дугаар хавсралт, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны үнэлгээний дүнг журмын 3 дугаар хавсралт, аймаг, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийг журмын 4 дүгээр хавсралтын дагуу тус тус гаргаж тайлангийн хамт ирүүлнэ.

4.5. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан ажилтнууд тайлантай танилцаад зорилтын хэрэгжилт, гарсан үр дүнгийн талаар судалгаа хийж, шаардлагатай бол газар дээр нь ажиллана.

4.6. Тайланд хяналт шинжилгээ хийхдээ түүнд тусгасан тоон үзүүлэлт болон зарим тоогоор илэрхийлж болох үзүүлэлтүүдийг статистикийн болон судалгаа шинжилгээний байгууллагын, түүнчлэн тухайн үйл ажиллагааны хүрээний асуудал хариуцсан бусад байгууллагын судалгааны үзүүлэлтүүд болон тайлант хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажиллаж үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ,

үнэлгээний материал зэрэгтэй харьцуулан үзэж үнэн зөвийг тогтооно;

4.7. Тайлан, судалгааны материалд шинжилгээ хийхдээ шинжлэх ухааны үндэслэлтэй түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

4.8 Үнэлгээний тайлангийн хамт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын тайланг ирүүлнэ.

**5. Үр дүнг үнэлэх аргачлал**

5.1. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний үзүүлэлтүүдийн ерөнхий үнэлгээг гүйцэтгэлийн болон үр дүнгийн үнэлгээний дунджаар тодорхойлно. Гүйцэтгэлийн үнэлгээний хувийг энэхүү журмын 5.6-д заасан аргаар тодорхойлно. Гүйцэтгэлийн хувийг шалгуур үзүүлэлтээр тогтоосон хүрэх түвшингийн үзүүлэлттэй харьцуулж үр дүнгийн үнэлгээний хувийг тодорхойлно.

5.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Засгийн газрын үндэсний хөтөлбөрүүд, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг тухайн яамны дангаар болон толгойлон хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний гүйцэтгэлээр үнэлнэ.

5.3. Төсвийн ерөнхийлөн захирагч /сайд/-аас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай болон төсвийн ерөнхийлөн захирагч сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нараас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлтийг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нараас гэрээг дүгнэсэн хувиар тодорхойлно.

5.4. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын тухайн жилд дэвшүүлсэн зорилтууд үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй хэрхэн уялдсаныг тодорхойлж үнэлгээ өгнө. Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө /бизнес стратегийн/-ний зорилт, арга хэмжээнүүд нь Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон үндэсний хөтөлбөрүүд, хууль тогтоомжоор тодорхойлогдсон Засгийн газрын бодлогын зорилтуудтай уялдсан байх бөгөөд төлөвлөгдсөн үйл ажиллагаа хэрэгжсэнээр тухайн зорилт бүрэн хэрэгжсэн байна.

5.5. Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газраас батлан хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд болон Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг баримт бичгээр дамжин хэрэгжиж буй төрийн бодлого иргэдийн амьдралд ямар өөрчлөлт гаргасныг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ болон хэрэглэгчийн үнэлгээ харуулна.

Хэрэглэгчийн үнэлгээг "Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлт", "Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт", "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт", "Яам, аймаг, нийслэлийн Засаг даргаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний үнэлгээ" гэсэн үзүүлэлтүүдээр жилд нэг удаа тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн насанд хүрсэн иргэдийн 5 хүртэл хувийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргана. Үзүүлэлт бүрт 1-5 баллын үнэлгээ өгөх бөгөөд санал асуулгын нэгдсэн дүнг үнэлгээний тайлантай хамт ирүүлнэ.

Санал асуулга явуулах ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг зохион байгуулна. Багийн бүрэлдэхүүнд санал асуулга, судалгааны чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн, судлаачид, үйлдвэрчний, ахмадын, эмэгтэйчүүдийн зэрэг төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна. Санал асуулгыг хөндлөнгийн нөлөөгүй байхаар зохион байгуулсан байна. Санал асуулга явуулахтай холбогдон гарах зардлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төсөвт тусгаж өгнө.

5.6. Үйл ажиллагаа бүрийн гүйцэтгэлийн хувийг дараахь томъёогоор бодож гаргана:

$$P_i = \frac{T_{\text{г}}}{T_{\text{р}}} \cdot 100;$$

Энд:

$P_i$ - i дүгээр үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь

$T_{\text{р}}$ - хүрэх үр дүнгийн төлөвлөгөө

$T_{\text{г}}$ - хүрсэн үр дүн

5.7 Үйл ажиллагааны хэрэгжилтийн болон үр дүнгийн үнэлгээний оноог дараахь томъёогоор бодож гаргана:

$$K_i = \frac{5}{100} \cdot P_i;$$

Энд: $K_i$ - i дүгээр үйл ажиллагааны гүйцэтгэлийн оноо

5.8. Зорилт тус бүрийн хэрэгжилтийн оноонуудын нийлбэрийг үйл

ажиллагааны нийт тоонд хувааж тухайн зорилтын гүйцэтгэлийн дундаж оноог гаргана.

$$K_a = \frac{\sum_{i=1}^{n} K_i}{n};$$

Энд $K_a$ а- дугаар зорилтын гүйцэтгэлийн дундаж хувь

$\sum_{i=1}^{n} K_i$ -тухайн зорилтод харгалзах үйл ажиллагаануудын онооны нийлбэр

*n* - үйл ажиллагааны тоо

5.8.1. Зорилтуудын гүйцэтгэлийн болон үр дүнгийн үнэлгээний хувийг оноогоор нь үржүүлсэн үржвэрүүдийн нийлбэрийг гүйцэтгэлийн хувиудын нийлбэрт хувааж жигнэсэн дундаж оноог тодорхойлно:

$$K_j = \frac{\sum_{j=1}^{n} P_j K_j}{\sum_{j=1}^{n} P_j};$$

Энд: $\sum P_j K_j$ - j –дүгээр зорилтын хэрэгжилтийн хувь, түүнд харгалзах онооны үржвэрүүдийн нийлбэр

$\sum_{j=1}^{n} P_j$ j – дүгээр зорилтын хэрэгжилтийн хувиудын нийлбэр.

5.9. Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараахь зарчмыг баримтална. Үүнд:

- Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр, үр дүн гарч, тогтворжсон бол 100 хувь;
- Тухайн заалтаар тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь /80.0-100.0 хүртэл хувь/;
- Тухайн заалтаар тавьсан зорилтдоо хүрэхийн тулд өөрсдөөс хамаарах бүх шийдвэр гарсан, хөрөнгө, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, шийдвэр гаргагч дээд байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь /60.0-80.0 хувь/;
- Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж буй ажлын түвшинг харгалзан 50.0 хувь /40.0-60.0 хувь/;
- Тухайн заалтад тусгагдсан асуудлыг шийдвэрлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж буй ажлын түвшинг харгалзан 30 хувь /20.0-40.0 хувь/;
- Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 /0-20.0/ хувийн биелэлттэй байна гэж үзнэ;
- Ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 үнэлгээ өгнө.

5.10. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээ нь үзүүлэлт бүрийн үнэлгээний онооны нийлбэрийг үзүүлэлтийн тоонд хувааж гаргасан дундаж оноогоор илэрхийлэгдэнэ.

**6. Шагнал, урамшуулал**

6.1. Ерөнхий үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан гурван яамны Төрийн нарийн бичгийн дарга, таван аймаг, нийслэлийн Засаг даргыг нэг сарын цалинтай тэнцэх мөнгөн шагналаар, авсан онооны дараалллын дагуу гурван яам, таван аймгийн Засаг даргын Тамгын газрыг дараахь шагналаар шагнаж урамшуулна. Үүнд:

1 дүгээр байр. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 3.0 сая төгрөгөөр;

2 дугаар байр. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 2.5 сая төгрөгөөр;

3 дугаар байр. Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 2.0 сая төгрөгөөр;

4 дүгээр байр. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 1.5 сая төгрөгөөр;

5 дугаар байр. Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрыг 1.0 сая төгрөгөөр.

6.2. Шагналд зарцуулах хөрөнгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсөвт жил бүр тусгана.

*Журмын 1 дүгээр хавсралт*

**ЯАМДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ**

200. . . оны жилийн эцсийн байдлаар

| № | Үзүүлэлт | | Гүйцэтгэлийн үнэлгээ | | Үр дүнгийн үнэлгээ | | Ерөнхий үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хувь | оноо | хувь | оноо | |
| 1 | 1. Бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүн | 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | | | | | |
| | | 2. Хууль тогтоомжийн хэрэгжилт | | | | | |
| | | 3. Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт | | | | | |
| | Үнэлгээний дундаж оноо | | | | | | |
| 2 | 2. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ | 1. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт | | | | | |
| | | 2. Улсын төсөв, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилт | | | | | |
| | | 3. Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт | | | | | |
| | Үнэлгээний дундаж оноо | | | | | | |
| 3. | 3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ | 1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт | | | | | |
| | | 2. Байгууллагаас дэвшүүлсэн зорилтууд нь үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөтэй уялдсан байдлын үнэлгээ | | | | | |
| | Үнэлгээний дундаж оноо | | | | | | |
| 4. | 4. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ | 1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ | | | | | |
| | | 2. Хэрэглэгчийн үнэлгээ | | | | | |
| | Үнэлгээний дундаж оноо | | | | | | |
| Ерөнхий үнэлгээ | | | | | | | |

*Журмын 2 дугаар хавсралт*

**ЯАМДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

200... оны жилийн эцсийн байдлаар

| № | Яамны нэр | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт | Оноо | ЖД оноо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Сангийн яам | 1. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн /1995 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг/ | | | | | |
| | | 2. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /хувь/ | | | | | |
| | | 3. ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх хувь | | | | | |
| | | 4. Хэрэглээний үнийн индекс | | | | | |
| | | 5. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлт /хувь/ | | | | | |
| | | 6. Дотоодын нийт бүтээгдэхүүнд гадаад өрийн эзлэх хувь | | | | | |
| | | 7. Нийт хөрөнгө оруулалт | | | | | |
| | | 8. Улсын төсвийн зарлага | | | | | |
| | | 9. Улсын төсвийн тэнцэл | | | | | |
| 2. | Гадаад хэргийн яам | 1. Олон талт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого, үүнд гарсан ахиц | | | | | |
| | | 2. Хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлого, үүнд гарсан ахиц | | | | | |
| | | 3. Гадаад харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх талаар хийсэн ажил | | | | | |
| | | 4. Гадаадад суугаа монгол иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар явуулж буй бодлого, арга хэмжээний биелэлт /хувь/ | | | | | |
| 3. | Хууль зүй, дотоод хэргийн яам | 1. Боловсруулж, батлуулсан хууль тогтоомж, эрх зүйн бусад актын тоо | | | | | |
| | | 2. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь | | | | | |
| | | 3. Хилийн хулгай, зөрчлийн илрүүлэлтийн хувь | | | | | |
| | | 4. Шалган нэвтрүүлэх боомтод илрүүлсэн зөрчлийн тоо | | | | | |
| | | 5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн хувь | | | | | |
| | | 6. Гадаадын иргэдийн бүртгэл, хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо | | | | | |
| | | 7. Төрийн архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлтийн тоо | | | | | |
| | | 8. Иргэний бүртгэл-ХААТР хөтлөлтийн тоо, мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн хувь | | | | | |
| 4. | Байгаль орчны яам | 1. Нийт газар нутагт тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь | | | | | |
| | | 2. Агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийн өөрчлөлт /хувиар/ | | | | | |
| | | 3. Хог хаягдлын дахин боловсруулалт, дахин ашиглалтын хувь | | | | | |
| | | 4. Ойжуулсан талбайн хэмжээ /мян.га/ | | | | | |
| | | 5. Уул уурхайн зориулалтаар олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлтийн хувь | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. | Барилга, хот байгуулалтын яам | 1. Шинээр ашиглалтад орсон орон сууцны тоо /айл/ | | | | | | |
| | | 2. Гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил / зэрэгцүүлэх үнээр, сая. төг / | | | | | | |
| | | 3. Хот байгуулалтын чиглэлээр боловсруулж гаргасан эрх зүйн актуудын тоо | | | | | | |
| | | 4. Газрын нөхөн сэргээлт, төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдсэн нийт талбайн хэмжээ /мян.га/ | | | | | | |
| | | 5. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /зэрэгцүүлэх үнээр, сая.төг/ | | | | | | |
| | | Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /биет хэмжээ/ | Тоосго /сая.шир/ | | | | | |
| | | | Цемент /мян.тн/ | | | | | |
| | | | Угсармал болон төмөр бетон, хөнгөн бетон эдлэл /мян.м3/ | | | | | |
| | | | Хаалга, цонх мян.м.кв | | | | | |
| | | | Өөрчлөлтийн дундаж хувь | | | | | |
| 6 | Боловсрол, соёл,шинжлэх ухааны яам | 1. Долоон настай хүүхдийн хамран сургалтын хувь | | | | | | |
| | | 2. ЕБС-ийн сургууль завсардалт хувь | | | | | | |
| | | 3. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь | | | | | | |
| | | 4. ЕБС-д суралцагчдын дотор нэгдүгээр ээлжид хичээллэгч сурагчдын эзлэх хувийн жин /хувь/ | | | | | | |
| | | 5. ЕБС-ийн анги дүүргэлт | | | | | | |
| | | 6. Мэргэжлийн багшийн хангалт /хувь/ | | | | | | |
| | | 7. Шинээр ашиглалтад орсон сургууль, цэцэрлэгийн талбай | | | | | | |
| | | 8. ШУТехнологийн санхүүжилтийн ДНБ-д эзлэх хувийн жин | | | | | | |
| | | 9. Тухайн жилд соёл, урлагийн үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо | | | | | | |
| 7. | Батлан хамгаалах яам | 1. Цэргийн нийт албан хаагчдын тоонд НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцохоор бэлтгэгдсэн болон уг арга хэмжээнд оролцож үүрэг гүйцэтгэсэн цэргийн албан хаагчдын эзлэх хувь | | | | | | |
| | | 2. Зэвсэг, техникийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн | | | | | | |
| | | 3. Батлан хамгаалах салбарт ажиллагсдын нийгмийн асуудалд зарцуулсан хөрөнгө оруулалтын дүн /сая.төг/ | | | | | | |
| | | 4. Өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогын өсөлт, үр дүн | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Зам, тээвэр, аялал жуулчлалын яам | 1. Бүх төрлийн тээврээр тээвэрлэсэн ачаа /мян.тн/, зорчигчийн тооны өөрчлөлт /хувь/ | | | | | |
| | | 2. Шинээр ашиглалтад орсон хатуу хучилттай замын урт / км / | | | | | |
| | | 3. Авто зам, түүний байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын гүйцэтгэл /сая.төг/ | | | | | |
| | | 4. Монгол Улсад гадаадаас ирсэн жуулчдын тоо | | | | | |
| 9. | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | 1. Ажилгүйдлийн түвшин | | | | | |
| | | 2. Ядуурлын индекс | | | | | |
| | | 3. Хүн амын дундаж орлого, амьжиргааны доод түвшингийн харьцаа /хувь/ | | | | | |
| | | 4. Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүн ам | | | | | |
| | | 5. Нийт бүртгэгдсэн ажилгүйчүүдийн тоонд ажилд зуучлагдан орсон хүний эзлэх хувь | | | | | |
| | | 6. Тэтгэврийн даатгалд хамрагдсан иргэдийн тоо | | | | | |
| | | 7. Үүнээс сайн дурын даатгалд хамрагдсан иргэдийн эзлэх хувь | | | | | |
| | | 8. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | | | | | |
| | | 9. Нийт ажиллагчдын тооны өсөлт | | | | | |
| 10. | Үйлдвэр, худалдааны яам | 1. ДНБ-д аж үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувийн жин | | | | | |
| | | 2. ДНБ-д экспортын эзлэх хувийн жин | | | | | |
| | | 3. Экспорт, импортын харьцаа | | | | | |
| | | 4. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний өсөлт /хувь/ | | | | | |
| | | 5. Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт /хувь/ | | | | | |
| | | 6. ЖДҮ-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний жилийн өсөлт /хувиар/ | | | | | |
| 11. | Түлш, эрчим хүчний яам | 1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт | | | | | |
| | | Үүнээс: Цахилгаан эрчим хүч /квт.цаг/ | | | | | |
| | | Дулааны эрчим хүч /Г/кал/ | | | | | |
| | | Хөрс хуулалт /мян.м3/ | | | | | |
| | | Нүүрс олборлолт /мян.тн/ | | | | | |
| | | 2. Нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жин /хувь/ | | | | | |
| | | 3. Цахилгаан түгээх сүлжээний алдагдал /хувь/ | | | | | |
| | | 4. Бүтээгдэхүүний экспорт: Нүүрсний экспорт /мян.тн/ | | | | | |
| | | Цахилгааны экспорт /квт.цаг/ | | | | | |
| | | 5. Эрчим хүчний системийн нийт өр, авлага /сая.төг/ | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Хүнс, хөдөө аж ахуйн яам | 1. Нэг хүнд ногдох хүнс, ХАА-н бүтээгдэхүүн /мян.төг/ | | | | | | |
| | | 2. Малын тоо /мян.тол/ | | | | | | |
| | | 3. Тариалсан талбай /мян.га/ | | | | | | |
| | | 4. Хураан авсан ургацын хэмжээ /мян.тн/ | | | | | | |
| | | Үүнд | Үр тариа | | | | | |
| | | | Төмс | | | | | |
| | | | Хүнсний ногоо | | | | | |
| | | | Өөрчлөлтийн дундаж хувь | | | | | |
| | | 5. Шинээр байгуулсан болон сэргээн засварласан уст цэг, усан сан, худгийн тоо | | | | | | |
| | | 6. Бэлтгэсэн хадлан /мян.тн/ | | | | | | |
| 13. | Эрүүл мэндийн яам | 1. Хүн амын дундаж нас /жил/ | | | | | | |
| | | 2. Эхийн эндэгдлийн харьцаа /100000 амьд төрөлтөд/ | | | | | | |
| | | 3. Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/ | | | | | | |
| | | 4. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/ | | | | | | |
| | | 5. 10000 хүнд ногдох халдварт өвчний гаралт | | | | | | |
| | | 6. 10000 хүнд ногдох сүрьеэ өвчний гаралт | | | | | | |
| | | 7. Сүрьеэгийн шууд хяналттай богино хугацааны /DOTS/ эмчилгээнд хамрагдагсдын эдгэрэлтийн хувь | | | | | | |
| | | 8. Нэг хүртэлх насны хүүхдийн өргөн дархлаажуулалтын хамралтын хувь | | | | | | |
| 14 | Улсын мэргэжлийн хяналтын газар | 1. Нэг байцаагчид ногдох актаар тавигдсан нөхөх төлбөр, торгууль, шийтгэврийн дүн /мян.төг/ | | | | | | |
| | | 2. Нэг байцаагчид ногдох барагдуулсан нөхөх төлбөр,торгууль, шийтгэврийн дүн /мян.төг/ | | | | | | |
| | | 3. Зөрчил, дутагдлын арилгалтын хувь | | | | | | |
| | | 4. Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын нийт байгууллагад эзлэх хувь | | | | | | |
| | | 5. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрахад чиглэсэн боловсруулж, шийдвэрлүүлсэн стандарт, эрх зүйн баримт бичгийн тоо | | | | | | |
| 15 | Онцгой байдлын ерөнхий газар | 1. Гамшгаас хамгаалах техник, багаж хэрэгслийн хангалтын хувь | | | | | | |
| | | 2. Гамшгийн тоо /гал түймэр, үер, шуурга гм/ | | | | | | |
| | | 3. Гамшгаас учирсан хохирол | | | | | | |
| | | 4. Хохирлыг арилгахад зарцуулсан хөрөнгө /сая.төг/ | | | | | | |
| | | 5. Гамшгаас сэргийлэх ажилд зарцуулсан хөрөнгө | | | | | | |

*Журмын 3 дугаар хавсралт*

### АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

200... оны жилийн эцсийн байдлаар

| № | Үзүүлэлт | | Гүйцэтгэлийн үнэлгээ | | Үр дүнгийн үнэлгээ | | Ерөнхий үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хувь | оноо | хувь | оноо | |
| 1 | 1. Бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээ | 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | | | | | |
| | | 2. Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт | | | | | |
| | Үнэлгээний дундаж оноо | | | | | | |
| 2 | 2. Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ | 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт | | | | | |
| | | 2. Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт | | | | | |
| | | 3. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт | | | | | |
| | | 4. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт | | | | | |
| | Үнэлгээний дундаж оноо | | | | | | |
| 3. | 3. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ | 1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний үүргийн биелэлт | | | | | |
| | | 2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт | | | | | |
| | Үнэлгээний дундаж оноо | | | | | | |
| 4. | 4. Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ | 1. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ | | | | | |
| | | 2. Хэрэглэгчийн үнэлгээ | | | | | |
| | Үнэлгээний дундаж оноо | | | | | | |
| Ерөнхий үнэлгээ | | | | | | | |

*Журмын 4 дүгээр хавсралт*

## АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

200... оны жилийн эцсийн байдлаар

| № | Үзүүлэлт | | | Өмнөх он | Тайлант он | Өөрчлөлт | Оноо | ЖД оноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1. Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт | 1. ДНБ /сая.төг/ | | | | | | |
| | | 2. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн /1995 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг/ | | | | | | |
| | | 3. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /хувь/ | | | | | | |
| | | 4. Хэрэглээний үнийн өөрчлөлт /хувь/ | | | | | | |
| | | 5.Төсвийн нийт зардалд өөрийн орлогын эзлэх хувь | | | | | | |
| | | 6. Нийт хөрөнгө оруулалт /сая.төг/ | | | | | | |
| | | 7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн /сая.төг/ | | | | | | |
| | | 8. Нэг хүнд ногдох аж үйлдвэрийн НБ /мян.төг/ | | | | | | |
| | | 9. ЖДҮ-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний жилийн өсөлт /хувиар/ | | | | | | |
| | | 10. ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэл /сая.төг/ | | | | | | |
| | | 11. Нэг хүнд ногдох хүнс, ХАА-н бүтээгдэхүүн /мян.төг/ | | | | | | |
| | | 12. Малын тоо /мян.тол/ | | | | | | |
| | | 13. Тариалсан талбай /мян.га/ | | | | | | |
| | | 14. Бэлтгэсэн хадлан /мян.тн/ | | | | | | |
| | | 15. Хураан авсан ургац /тн/ | Үр тариа | | | | | |
| | | | Төмс | | | | | |
| | | | Хүнсний ногоо | | | | | |
| | | | Малын тэжээл | | | | | |
| | | 16. Цахилгаан дамжуулах сүлжээний алдагдал /хувь/ | | | | | | |
| | | 17. Борлуулсан цахилгаан дулааны үнийн индекс | | | | | | |
| | | 18. Бүх төрлийн тээврээр тээвэрлэсэн ачаа, зорчигчийн тооны өөрчлөлтийн хувь | | | | | | |
| | | 19. Гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил /зэрэгцүүлэх үнээр, сая төг/ | | | | | | |
| | | 20. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /зэрэгцүүлэх үнээр, сая.төг/ | | | | | | |
| | | 21. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт /биет хэмжээ/ | Тоосго /сая.шир/ | | | | | |
| | | | Цемент /мян.тн/ | | | | | |
| | | | Гурил /тн/ | | | | | |
| | | | Үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн мах /тн/ | | | | | |
| 2. | Нийгмийн үзүүлэлтүүд | 1. Нэгдүгээр ангид элсэн орсон хүүхдийн 7-8 насны хүүхдийн тоонд эзлэх хувь | | | | | | |
| | | 2. Дунд сургуульд элсэгчдийн харьцаа /хувь/ | | | | | | |
| | | 3. ЕБС-д суралцагсдын нийт тоонд нэгдүгээр ээлжид хичээллэгч сурагчдын эзлэх хувийн жин | | | | | | |
| | | 4. Мэргэжлийн багшийн хангалт /хувь/ | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 5. Анги дүүргэлт | | | | | | |
| | | 6. Хүн амын дундаж нас /жил/ | | | | | | |
| | | 7. Эхийн эндэгдэл /тоо/ | | | | | | |
| | | 8. Нялхсын эндэгдэл /1000 хүүхдэд ногдох/ | | | | | | |
| | | 9. Халдварт өвчний гаралт /тоо/ | | | | | | |
| | | 10. Урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан байдал /хувь/ | | | | | | |
| | | 11. Ажилгүйдлийн түвшин | | | | | | |
| | | 12. Ядуурлын индекс | | | | | | |
| | | 13. Хүн амын дундаж орлого, амьжиргааны баталгаажих доод түвшингийн харьцаа /хувь/ | | | | | | |
| | | 14. Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент /хувь/ | | | | | | |
| | | 15. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | | | | | | |
| | | 16. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын тоо | | | | | | |
| | | 17. Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн хүний тоо | | | | | | |
| | | 18. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын барагдуулалт /хувь/ | | | | | | |
| | | 19. Эрүүлжүүлэгдсэн хүний тоо | | | | | | |
| 3. | Хөгжлийн үзүүлэлт | 1. Нийт газар нутагт тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь | | | | | | |
| | | 2. Агаар дахь бохирдуулагч бодисын агууламжийн өөрчлөлт /хувиар/ | | | | | | |
| | | 3. Хог хаягдлын дахин боловсруулалт, дахин ашиглалтын хувь | | | | | | |
| | | 4. Ойжуулсан талбайн хэмжээ /мян.га/ | | | | | | |
| | | 5. Шинээр ашиглалтад орсон хатуу хучилттай замын урт /км/ | | | | | | |
| | | 6. Нэг хүнд ногдох шинээр ашиглалтад орсон орон сууцны талбайн хэмжээ /м2/ | | | | | | |
| | | 7. Төвлөрсөн эрчим хүчний сүлжээний хүчин чадлын өсөлт /хувиар/ | | | | | | |
| | | 8. Нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жин /хувь/ | | | | | | |
| | | 9. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт /сая.төг/ | | | | | | |
| | | 10. Шинээр ашиглалтад орсон: орон сууц /айлаар/ | | | | | | |
| | | ЖДҮ /тоо/ | | | | | | |
| | | ажлын байр /тоо/ | | | | | | |
| | | 11 Уул уурхайн олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлтийн хувь | | | | | | |
| | | 12. Шинээр байгуулсан болон сэргээн засварласан уст цэг, усан сан, худгийн тоо | | | | | | |
| | | 13. Цэвэр, бохир усны төвлөрсөн хангамжид хамрагдсан өрхийн нийт өрхийн тоонд эзлэх хувь | | | | | | |
| | | 14. Халуун усны тоо | | | | | | |
| | | 15. Суурин телефон цэг | | | | | | |
| | | 16. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоо | | | | | | |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

### Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын 2005 оны 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан ажиллах байгууллагуудыг хавсралт ёсоор батлагсугай.

2. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон салбарын шинээр боловсруулагдах үндсэн чиглэл, төсөл, хөтөлбөрүүдэд тусгаж, харилцан уялдуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэн 2015 онд хүрвэл зохих түвшинд хүргэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг дайчлах, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж хэлэлцүүлэх, улмаар дотоодоос шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Сангийн сайд Н.Баяртсайханд үүрэг болгосугай.

4. Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон бодлогын арга хэмжээний төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжүүлэлт, мониторингийн үйл ажиллагааг энэхүү тогтоолын хавсралтад тусгагдсан ажил үүргийн хуваарийн дагуу салбар, яамд, төв, орон нутгийн хооронд нягт уялдаатай зохион байгуулж ажиллахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Эрүүл мэндийн сайд Л.Гүндалай, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин, Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт, Үйлдвэр, худалдааны сайд Б.Жаргалсайхан, Гадаад хэргийн сайд Н.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэд нарт тус тус даалгасугай.

5. Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын банк, санхүүгийн байгууллагууд, хандивлагч орнуудтай хамтран ажиллаж, холбогдох тайлан, мэдээг тухай бүрт гарган өгч ажиллах, эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд дутагдаж байгаа санхүүгийн эх үүсвэрийг тооцон олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, техникийн туслалцаатайгаар шийдвэрлэх чиглэлээр ажиллахыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Гадаад хэргийн сайд Н.Энхболд болон холбогдох бусад сайд нарт үүрэг болгосугай.

6. Улсын Их Хурлаас өгсөн үүргийн дагуу Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явц байдлын тайланг 2007 оноос эхлэн хоёр жил тутамд нэг удаа бэлтгэн гаргаж, тухайн жилийн 5 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулан Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд тайлагнаж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан болон холбогдох бусад сайд нарт үүрэг болгосугай.

7. Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх явцад төрийн бус байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулах, тэдэнд сурталчлан таниулах, тодорхой зорилтыг хэрэгжүүлэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр олон нийттэй харьцах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболд, Гадаад хэргийн сайд Н.Энхболд, Сангийн сайд Н.Баяртсайхан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэд нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД — М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД — Н.БАЯРТСАЙХАН

### МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ХАРИУЦАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГУУД

| Зорилго | Зорилт | Үндсэн хариуцах эзэн | Хамтарч хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|---|
| **Зорилго 1.** Ядуурал, өлсгөлөнг бууруулах | **Зорилт 1.** Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах | НХХЯ, ҮХЯ | СЯ, ХХААЯ, БСШУЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |
| | **Зорилт 2.** Хоол тэжээлийн дутагдалтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах | ХХААЯ, ҮХЯ | ЭМЯ, ГХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |
| | **Зорилт 3.** Залуучуудад зориулсан таатай, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх. Газар ашиглах боломжийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх журмыг хөнгөвчлөх, ажил эрхлээгүй иргэн бичил зээл авах боломжийг бий болгох замаар ажилгүй хүмүүс, ялангуяа залуучуудад зориулсан ажлын байрыг бий болгоно | НХХЯ, ҮХЯ | БХБЯ, СЯ, ХХААЯ, БОЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |
| | **Зорилт 4.** Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжигсдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн хамгаалалтыг бий болгох, ажлын байраар хангах, орон сууц, эмнэлэг, боловсрол, соёлын болон нийгмийн бусад үйлчилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх | НХХЯ, ҮХЯ | ХЗДХЯ, БХБЯ, ЭМЯ, БСШУЯ, БОЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |
| **Зорилго 2.** Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших | **Зорилт 5.** 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох | БСШУЯ | СЯ, ТЭХЯ, БХБЯ, ЭМЯ, ГХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |
| **Зорилго 3.** Хүйсийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх | **Зорилт 6.** 2005 онд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын түвшинд хүйсийн ялгааг арилгах | НХХЯ, БСШУЯ | Төрийн албаны зөвлөл, ХЗДХЯ, ЭМЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний Хороо, ТББ |
| **Зорилго 4.** Хүүхдийн эндэгдлийг бууруулах | **Зорилт 7.** 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд гуравны хоёроор бууруулах | ЭМЯ | СЯ, НХХЯ, ТЭХЯ, БХБЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |
| **Зорилго 5.** Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах | **Зорилт 8.** Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд дөрөвний гурваар бууруулах | ЭМЯ | СЯ, ТЭХЯ, БХБЯ, НХХЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |
| **Зорилго 6.** Бэлгийн замын халдварт өвчин, хүний дархлалын халдварт вирус /ХДХВ/, ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах | **Зорилт 9.** 2015 он гэхэд Хүний дархлалын халдварт вирус /ХДХВ/, Дархлалын олдмол вирус /ДОХ/ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх | ЭМЯ | НХХЯ, БСШУЯ, ХЗДХЯ, ЗТАЖЯ, СЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |

| | | | |
|---|---|---|---|
| | **Зорилт 10.** 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах | ЭМЯ | НХХЯ, БСШУЯ, ХЗДХЯ, ТББ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| | **Зорилт 11.** Хүн амын шүдний өвчлөлтэй тэмцэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх | ЭМЯ | НХХЯ, БСШУЯ, ТББ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| **Зорилго 7.** Байгаль орчны тогтвортой байдлыг хангах | **Зорилт 12.** Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх | БОЯ | ТЭХЯ, БХБЯ, ЗТАЖЯ, ҮХЯ, СХЗТ, ЭМЯ, СЯ, ТББ |
| | **Зорилт 13.** Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах | БОЯ | БХБЯ, ХХААЯ, ЗТАЖЯ, ТЭХЯ, СХЗТ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ |
| | **Зорилт 14.** 2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын хувийг 2 дахин бууруулах | БХБЯ | БОЯ, ЭМЯ, УсХЭГ, СЯ, ҮХЯ, СХЗТ, ТББ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| | **Зорилт 15.** 2015 он гэхэд орон байрны нөхцөл муу хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц сайжруулах | БХБЯ | ЗТАЖЯ, СЯ, ҮХЯ, ЭМЯ, СХЗТ, ТЭХЯ,ТББ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| **Зорилго 8.** Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх | **Зорилт 16.** Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх таатай нөхцөл бүрдүүлэх | ҮХЯ, СЯ | ГХЯ, ТББ |
| | **Зорилт 17.** Далайд гарцгүй Монгол орны онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улс илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх | ЗТАЖЯ | ГХЯ, ҮХЯ, БОЯ, ТББ |
| | **Зорилт 18.** Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх | СЯ | |
| | **Зорилт 19.** Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, "Мэдээлэлжсэн нийгэм" байгуулах | МХХТГ | ХЗДХЯ, ТББ |
| **Зорилго 9.** Хүний эрхийг баталгаажуулах ардчилсан засаглалыг хөгжүүлэх | **Зорилт 20.** Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэж, чандлан сахих, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох | ЗГХЭГ | ХЗДХЯ, ГХЯ, НХХЯ, УСГ, Хүний эрхийн үндэсний комисс, ТББ |
| | **Зорилт 21.** Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх | Шадар сайд | ЗГХЭГ, ХЗДХЯ, ГХЯ, УСГ, ТББ |
| | **Зорилт 22.** Авилгалыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх | ХЗДХЯ | ЗГХЭГ, НХХЯ, УСГ, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, ТББ |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 3 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

**Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай**

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангахтай холбогдсон удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх ажилтай нягт уялдуулан зохион байгуулж төрийн захиргааны төв, орон нутгийн бүх шатны байгууллага, төрийн бус болон хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллага, иргэдийг татан оролцуулах чиглэлээр ажиллахыг сайд, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАТБОЛД

*Засгийн газрын 2006 оны 54 дүгээр тогтоолын хавсралт*

### ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

1. Боловсролын хүртээмж, чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, хүний хөгжлийн түвшинг ахиулах;

2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажиллагчид бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын дэвшилттэй арга, хэлбэрийг ашиглан ажиллагсдын зах зээлд өрсөлдөх ур чадвар, чадавхийг нэмэгдүүлэх;

3. Эдийн засгийн бодит өсөлтийг тогтворжуулж, түүний үр шимийг иргэн бүр хүртэхүйцээр нийгмийн баялгийн хуваарилалтыг оновчтой болгож, дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлэх;

4. Хөдөлмөр эрхлэж орлогоо нэмэгдүүлэхэд нь бичил зээл, санхүүгийн бусад дэмжлэг үзүүлэх замаар ядуурлыг бууруулах;

5. Иргэдэд газар болон үл хөдлөх хөрөнгө өмчлөх таатамжтай орчин бий болгох, бага, дунд орлоготой иргэдийн орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах эрх зүйн орчин бүрдүүлэх;

6. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих дэд бүтэц, татвар, санхүүгийн таатамжтай орчин бий болгон ажлын байр нэмэгдүүлж ажилгүйдлийг багасгах;

7. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлэх, усан цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлж, "Мянганы зам"-ыг барих ажлыг үргэлжлүүлэх, эрчимжсэн хөдөө аж ахуйг түлхүү хөгжүүлж, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах;

8. Засаг захиргааны хуваарийг үе шаттайгаар боловсронгуй болгох, орон нутгийн бие даасан байдлыг хангах, төвлөрлийг сааруулах, "Цахим засаглал"-ыг хөгжүүлж, төрийн үйлчилгээний үр ашиг, шуурхай байдлыг нэмэгдүүлэх замаар хүнд суртал, авилгалын илрэлтэй тэмцэх;

9. Байгаль хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж, байгаль орчны доройтол, агаарын бохирдлыг багасгах;

10. Уул уурхай, эрдэс баялгийн салбарыг олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай болгох, хөрөнгө оруулалтын харилцан ашигтай бодлогыг тууштай баримтлан, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 3 дугаар сарын 22-ны өдөр** **Дугаар 55** **Улаанбаатар хот**

### Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай" Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоолын хавсралтын 3.8-ын "... Харин 2005 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш их, дээд сургуульд шинээр элсэн орсон нэг хүүхдийнх нь сургалтын зардлыг төлөх асуудлыг төр хариуцахгүй." гэснийг хассугай.

2. Төрийн зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж байгаа гэрээт ажилчдын гэр бүлээс нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд, мэргэжлийн сургуульд 2005-2006 оны хичээлийн жилд элсэн орсон 1 хүүхдийнх нь сургалтын төлбөрийг Сургалтын төрийн сангаар дамжуулан зохих журмын дагуу олгоход шаардагдах зардлыг 2006 оны төсөвт нэмж тусгах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшин, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт хариуцуулсугай.

3. Өөрийн орлогоороо зарлагаа нөхөн ажилладгаас бусад төсөвт байгууллагад гэрээгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа гэрээт ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх чиглэл баримтлан ажиллахыг төсвийн байгууллагын Ерөнхий менежер нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД** **Н.БАЯРТСАЙХАН**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2006 оны 3 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 56** **Улаанбаатар хот**

### Арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

"Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг батлах тухай" Улсын Их Хурлын 2005 оны 67 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хүрээнд "Үндсэн чиглэлийн зорилтуудыг 2006 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралт ёсоор батлсугай.

2. "Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийг батлах тухай" Улсын Их Хурлын 2005 оны 67 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгагдсан арга хэмжээний жагсаалтаас 2006 оны төсөвт хөрөнгийн эх үүсвэр нь шийдвэрлэгдээгүй зарим арга хэмжээг нарийвчлан судалж, төсвийн бус хөрөнгийн бусад эх үүсвэрээр шийдвэрлэх боломжийг хянан үзэх, шаардлагатай бол 2007-2009 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулах арга хэмжээ авахыг холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.

3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2006-2008 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, түүний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийн явц, хүрсэн үр дүнгийн талаар 2006 оны 9 дүгээр сард, хэрэгжилтийг 2007 оны 2 дугаар сард багтаан тус тус Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (С.БАТБОЛД)-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

**САНГИЙН САЙД** **Н.БАЯРТСАЙХАН**

Засгийн газрын 2006 оны 30 дугаар тогтоолын хавсралт

## ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТУУДЫГ 2006 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үндсэн чиглэлд тусгагдсан зорилтууд | Уг зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хариуцан хэрэгжүүлэх үндсэн яам, газар | Хэрэгжүүлэх явцад оролцох бусад яам, газар |
|---|---|---|---|---|
| | Бүлэг 1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ТЭНЦВЭР, ӨСӨЛТ | | | |
| 1 | Инфляцийг зохистой түвшинд байлгах бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх | 1.1. Нефть бүтээгдэхүүнд ногдуулж байгаа гааль, НӨАТ, онцгой болон бусад албан татваруудын нөлөөллийг судалж, дотоод зах зээлд борлуулах үнийн нэмэгдэл нь гадаад зах зээл дээр нэмэгдсэн хэмжээнээс их гүй байхаар холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж, зохицуулалт хийх | СЯ | ҮХЯ |
| | | 1.2. Дотоодын зах зээлд нийлүүлэх махыг НӨАТ-аас чөлөөлж нийлүүлэлтийг урамшуулах арга хэмжээ авах | ХХААЯ | СЯ |
| | | 1.3. Мах бэлтгэн нийлүүлэгчдэд нэг удаагийн зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг төлөвлөгдсөний дагуу хэрэгжүүлэх, хэрэгжилтийн явцад хяналт тавих, үр дүнг тооцож үзэх | Нийслэлийн ЗДТГ | ХХААЯ, СЯ |
| | | 1.4. Эдийн засаг дахь зээлийн хүүгийн түвшин болон түүнийг бууруулах боломжийг мөнгө, төсөв, татварын бодлоготой уялдуулан судалж хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэх | Монгол банк | СЯ |
| | | 1.5. Үйлдвэрлэгчийн бөөний үнийн индексийн талаар нарийвчилсан судалгаа хийж, албан ёсны статистик мэдээнд хамруулах арга хэмжээ авах | ҮСГ | СЯ |
| | | 1.6. Бөөний худалдааны сүлжээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хүн амыг чанар сайтай хүнс, өргөн хэрэглээний бараагаар, үйлдвэрлэлийг түүхий эдээр тасралтгүй хангах замаар зах зээлийн бодит үнийн түвшинг тогтоож, хот, хөдөөгийн хоорондох үнийн зөрүүг багасгах | ҮХЯ | |
| | | 1.7. Бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор эрх зүйн орчныг бүрдүүлж, түүхий эдийн бэлтгэлийг сайжруулах, бөөний худалдааг дэмжсэн арга хэмжээ авах | ҮХЯ | |
| 2 | Валютын ханшийн огцом өөрчлөлтөөс сэргийлж, гадаад валютын нөөцийг зохистой удирдах | 2.1. Гадаад зах зээл дэх валютын ханшийн өөрчлөлтийг тогтмол тандан судалж, ханшийн огцом өөрчлөлт гарахаас сэргийлэх, ханшийн огцом өөрчлөлт гарсан нөхцөлд авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах | Монгол банк | СЯ |
| | | 2.2. Макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүдтэй уялдуулан төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханшны харьцангуй тогтвортой байдлыг хангах | Монгол банк | СЯ |
| 3 | Банк, санхүүгийн салбарыг бэхжүүлэх, санхүүгийн зах зээлд төрийн оролцоог бууруулж, санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих | 3.1. Монгол банк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны уялдааг хангахад чиглэгдсэн хамтарсан Санамж бичгийг боловсруулж гаргах | СЯ | Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банк |
| | | 3.2. Түрээсийн үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлж, түрээсийг санхүүгийн зах зээлд өргөн нэвтрүүлэх, дэлгэрүүлэх | Санхүүгийн зохицуулах хороо | СЯ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3.3. Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн чадавхийг сайжруулж, эрсдэлийг бууруулах замаар жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээний таатай орчин бүрдүүлэх | Санхүүгийн зохицуулах хороо | СЯ |
| | | 3.4 "Ипотекээр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай" багц хуулийн төслийг эцэслэн боловсруулж, УИХ-аар батлуулах | БХБЯ | СЯ, ХЗДХЯ |
| 4 | Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс "Гадаад өрийн талаар баримтлах стратеги" боловсруулан, өрийг Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр зохицуулан шийдвэрлэж байх | 4.1. Гадаад өрийн талаар баримтлах стратегийг боловсруулан УИХ-аар батлуулах | СЯ | ҮХЯ |
| | | 4.2. Гадаад өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хязгаарын талаар УИХ-аас тогтоож өгсөн дээд хэмжээг тогтмол хангаж байх талаар төлөвлөсөн цогцтой бодлого, арга хэмжээ авч ажиллах | СЯ | |
| 5 | Гадаад худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлж, экспортод гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулан, экспортыг нэмэгдүүлэх | 5.1. АНУ, Япон, БНСУ зэрэг оронтой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэсгийг байгуулж, холбогдох судалгаа хийх | ҮХЯ | ГХЯ |
| | | 5.2. Олон талт худалдааны ДОХА-гийн үе шатны хэлэлцээнд идэвхтэй оролцох зорилгоор худалдааны сайд нарын хуралдааны бэлтгэл ажлыг хангах, далайд гарцгүй эмзэг эдийн засагтай орны байр суурийг хамгаалж ажиллах | ҮХЯ | ГХЯ |
| | | 5.3. ХАА-н хэлэлцээ, худалдааг хөнгөвчлөх, үйлчилгээ, худалдаа зэрэг хэлэлцээнд өөрийн орны ашиг сонирхлыг хамгаалах | ҮХЯ | |
| | | 5.4. Ази, Номхон далайн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа /АПЕК/-нд нэгдэн орох Засгийн газрын зорилтын хүрээнд АПЕК-ийн ажлын хэсгийн хуралд идэвхтэй оролцох | ҮХЯ | ГХЯ, СЯ |
| | | 5.5. Цагааннуур тосгоныг баруун бүсийн эрчим хүчний сүлжээнд холбох Өлгий-Цагааннуурын 35 квт-ын цахилгаан дамжуулах шугам барих техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах | ТЭХЯ | СЯ, ҮХЯ |
| | | 5.6. Өлгий-Цагааннуурын чиглэлд баригдаж буй 30 км хатуу хучилттай замын ажлыг дуусгах | ЗТАЖЯ | СЯ , ҮХЯ |
| | | 5.7. "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийг БНХАУ-тай хамгийн ойр дөт замаар холбох (250 км) боломжийг судалж, хатуу хучилттай зам тавиулах талаар БНХАУ, ОХУ-ын Засгийн газартай гэрээ байгуулах бэлтгэлийг хангах | ЗТАЖЯ | ЗТАЖЯ, СЯ, ҮХЯ |
| | | 5.8. Улаангом-Хандгайтын чиглэлийн 58 км хатуу хучилттай авто замыг барих | ЗТАЖЯ | СЯ |
| | | 5.9. Чойр-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай зам барих ажлыг үргэлжлүүлэх | ЗТАЖЯ | СЯ |
| | | 5.10. "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсийг байгуулах ерөнхий төлөвлөгөө, хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Цагааннуур тосгоны ерөнхий төлөвлөгөөг хийлгэх | ҮХЯ | |
| | | 5.11. "Алтанбулаг" худалдааны чөлөөт бүсийг байгуулах ажлыг үргэлжлүүлж, бүсийн дэд бүтцийг барьж байгуулах төслийн хөрөнгийн эх үүсвэрийг | ҮХЯ | СЯ, БХБЯ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | шийдэж, хэрэгжүүлж эхлэх | | |
| | | 5.12. Чөлөөт бүсүүдийн нөөц, давуу талыг нээж, зах зээлд бүрэн үр ашигтай ашиглахад чиглэгдсэн зорилтот хөтөлбөр боловсруулан улсын нэгдсэн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх | ҮХЯ | |
| | | 5.13. Эдийн засгийн чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эхлүүлэхэд онцгой анхаарч ажиллах | ҮХЯ | |
| | | 5.14. Зүүн хойд Ази, АСЕАН, АРЕС-ийн орнуудтай олон талтаар бүс нутгийн хэмжээнд худалдааг өргөжүүлэх боломжийг судлах, худалдаа, үйлчилгээг нэмэгдүүлэх, шинэ зах зээл нээх, түнш орнуудын зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрэх боломжийг судлах зэрэг судалгааг хийх | ҮХЯ | |
| | | 5.15. Худалдааны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судалж санал боловсруулах | ҮХЯ | |
| | | 5.16. Гадаадын захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг оедол, сүлжмэлийн үйлдвэрүүдийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, татварын хөнгөлөлт үзүүлэх бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэх | ҮХЯ | СЯ |
| | | 5.17. Монголын бараа, үйлчилгээг таниулан сурталчилах зорилготой "Монгол бренд" төслийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх | ҮХЯ | |
| | | 5.18. Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг 2010 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, Оросын талтай тохиролцох | ҮХЯ | |
| | | 5.19. "Худалдааны бодлого, хэлэлцээг дэмжих" төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж эхлэх | ҮХЯ | |
| 6 | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг хамгаалах таатай орчин бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах | 6.1. Монголд Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулах | СЯ, ҮХЯ | ЗТАЖЯ, БХБЯ |
| | | 6.2. Монгол Улсаас гадаад оронд суугаа Элчин сайдын яам, Байнгын төлөөлөгчийн газраар дамжуулан хөрөнгө оруулалтын чиглэлээр сурталчилгаа явуулах | ГХЯ | ҮХЯ |
| | | 6.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад үйл ажиллагаа явуулах тодорхой, тогтвортой эрх зүйн орчинг бүрдүүлэхийн тулд олон улсын түвшинд нийцсэн, үр ашигтай нь нотлогдсон дүрэм, журам, стандартуудыг авч хэрэглэхийг дэмжих, тогтвортой байдлын гэрээ байгуулж ажиллах | ҮХЯ | |
| | | 6.4. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад таатай орчин бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох | СЯ | ҮХЯ |
| | | 6.5. Хүрэн нүүрсийг шингэрүүлэн нефтийн бүтээгдэхүүн гаргах судалгааны ажлыг эрчимжүүлэх, нүүрс шингэрүүлэх үйлдвэр барих техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, нүүрсний боловсруулалтад хөрөнгө оруулах таатай нөхцөл бий болгох, эрх зүйн орчинг боловсронгуй болгох | ТЭХЯ | СЯ, ХЗДХЯ |
| | | 6.6. Шинжлэх ухааны байгууллагуудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар шинжилгээ, судалгааны ажлын үр өгөөжийг дээшлүүлэх | БСШУЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | ДНБ-д эзлэх төсвийн орлого, зарлагын зохистой харьцааг хангаж, улмаар төсвийн алдагдлыг бууруулах | 7.1. 2006 оны гүйцэтгэлээр төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувийг 36,6 хувиас ихгүй, төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг 40,0 хувиас ихгүй байлгах, төсвийн нийт тэнцлийн алдагдлыг 3,5 хувиас ихгүй байлгах чиглэлээр төсвийн нэгдсэн бодлогын удирдлагыг хэрэгжүүлж, төрийн сангийн нэгдсэн тогтолцоогоор дамжуулан хяналт тавьж ажиллах | СЯ | |
| | | 7.2. Улсын төсвийн зарлагын шинэчлэлийг олон улсын банк, санхүүгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, салбарын яамдаас гарч буй санал, санаачилгын дагуу төсвийн зардал хэмнэх арга хэмжээг тууштай авч хэрэгжүүлэх | СЯ | Яамд |
| | | 7.3. Татварын багц хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээнд татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, татварын ачааллыг бууруулах чиглэлээр Засгийн газраас татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, зарим хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлэн батлуулах | СЯ | УХЯ, УТЕГ |
| 8 | Төсвийн болон зээл тусламжийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн дагуу хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх | 8.1. Улсын хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөрийг дотоод, гадаадын хөрөнгө оруулалтын бүхий л эх үүсвэрийг хамарсан байдлаар боловсруулж, 2007-2009 онуудын Төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах явцад түүнд тусган улмаар 2007 оны төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төслийг хөтөлбөр байдлаар тусгаж эхлэх | СЯ | Яамд |
| | | Бүлэг 2. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРЫН БОДЛОГО | | |
| 9 | ДНБ-д боловсруулах үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийг нэмэгдүүлж, төрөлжилтийг гүнзгийрүүлнэ | 9.1. Боловсруулах үйлдвэр, үйлчилгээний салбарын дэд бүтцийг хөгжүүлэхэд улсын хөрөнгө оруулалтыг түлхүү чиглүүлэх | УХЯ | ТЭХЯ, БХБЯ, ЗТАЖЯ, ХХААЯ, СЯ |
| | | 9.2. Боловсруулах үйлдвэр, үйлчилгээний салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах | УХЯ | |
| | | 9.3. Эх орны түүхий эдийн нөөцөд тулгуурлан өргөн хэрэглээний болон хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх | УХЯ | |
| | | 9.4. Мод боловсруулах үйлдвэрүүдэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар модыг бүрэн боловсруулах, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | УХЯ | |
| | | 9.5. Төрөөс хувийн хэвшилд үзүүлэх үйлчилгээний хүнд суртал, шат дамжлагыг багасгах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх | УХЯ | СЯ |
| 10 | Эрчим хүчний хүрэлцээ хангамжийг сайжруулж, цахилгаан, эрчим хүчний байнгын эх үүсвэргүй өрхийн тоог бууруулах | 10.1. Дэргэний 12 мВт, Тайширийн 11 мВт-ын усан цахилгаан станцуудын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж, Үенчийн усан цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах | ТЭХЯ | |
| | | 10.2. Таван толгойн цахилгаан станц (250 мВт-аас доошгүй хүч чадалтай)-ын судалгаа хийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах | ТЭХЯ | |
| | | 10.3. Улаангом-Малчин-Хяргас сумын 110 квт-ын цахилгаан дамжуулах шугамыг барьж эхлүүлэх | ТЭХЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 10.4. Улаанбаатар-Мандалговь-Оюу-толгойн 220 кВ-ын хос цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах | ТЭХЯ | |
| 11 | Эрчим хүчний үйлдвэрлэлийг эдийн засгийн төлөвлөсөн өсөлтийг хангахуйц хэмжээнд эрчимтэй хөгжүүлэх | 11.1. Дулааны IY цахилгаан станцын 2 дугаар шатны шинэчлэлт, дулааны үр ашгийн, Улаанбаатар хот, 6 аймагт хэрэгжиж байгаа цахилгаан шугам сүлжээний алдагдлыг багасгах төслийн ажлыг хийж дуусгах | ТЭХЯ | |
| | | 11.2. Диспетчерийн төвийн хяналт, мэдээллийн системийн болон дамжуулах сүлжээний шинэчлэлтийн төслийг үргэлжлүүлж, Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн түгээх сүлжээний алдагдал бууруулах төслийг хэрэгжүүлж эхлэх | ТЭХЯ | |
| | | 11.3. Зүүн бүсийн эрчим хүчний системийг төвийн эрчим хүчний системд холбох ажлын хүрээнд Баруун–Урт- Өндөрхааны 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг үргэлжлүүлэн барих | ТЭХЯ | |
| | | 11.4. Говийн бүс нутгийн цахилгаан хангамжийн судалгааны ажлыг хэрэгжүүлж уул уурхай, ашигт малтмалын чиглэлийн томоохон хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангах асуудлыг шийдвэрлэх ажлыг олон талын оролцоотойгоор эхлүүлэх | ТЭХЯ | |
| | | 11.5. Шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээг нэмэгдүүлж, хийн түлшний зохицуулалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох | ТЭХЯ | БОЯ, ҮХЯ Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| | | 11.6. Төв аймгийн Зуунмод хотын дулааны гадна шугамыг шинэчлэх | ТЭХЯ | |
| | | 11.7. Говь-Алтай аймгийн Тайширын усан цахилгаан станц-Улиастайн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих | ТЭХЯ | |
| | | 11.8. Ховд аймгийн Үенчийн усан цахилгаан станц-Булган сумын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих | ТЭХЯ | |
| | | 11.9. Хөвсгөл аймгийн Мөрөн-Арбулаг сумын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих | ТЭХЯ | |
| | | 11.10. Дундговь аймгийн Хулд-Өлзийт сумын 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих | ТЭХЯ | |
| | | 11.11. Увс аймгийн Алтанцөгц-Ховд сумын 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих | ТЭХЯ | |
| | | 11.12. Өвөрхангай аймгийн Баянтээг-Нарийнтээл сумын 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барих | ТЭХЯ | |
| | | 11.13. Дулааны алдагдлыг багасгах зорилгоор орчин үеийн шинэ технологи, материалыг нэвтрүүлэх зорилт тавьж ажиллах | ТЭХЯ | |
| 12 | Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 12.1. Сэргээгдэх эрчим хүчний болон эрчим хүч хэмнэх тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах | ТЭХЯ | |
| | | 12.2. Эрчим хүчний нэгдсэн системд холбогдоход хүндрэлтэй төв, суурин газарт нар, салхи, усны эрчим хүч ашиглах судалгаа хийнэ. Хөвсгөлийн Эрдэнэбулган, Завханы Тосонцэнгэлийн усан цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулах | ТЭХЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 12.3. Говь, хээрийн бүсийн түлшний асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хүрээнд сэргээгдэх эрчим хүч болон орон нутгийн зарим нүүрсний ордыг ашиглахад дэмжлэг туслалцаа үзүүлэх | ТЭХЯ | |
| 13 | Уул, уурхайн олборлох аж үйлдвэрийн шинэ хүчин чадлыг бий болгохын зэрэгцээ энэ салбарын бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлэх | 13.1. Тавтын алт, Цавын холимог металлын орд, Төмөртэйн төмрийн хүдрийн ордуудыг ашиглах үйлдвэрийг ашиглалтад оруулах | ҮХЯ | ТЭХЯ |
| | | 13.2. Тавантолгойн коксжих нүүрсний орд газарт эрчим хүч, кокс-химийн цогцолбор барих бодлогыг тодорхойлох | ТЭХЯ | БОЯ, ЗТАЖЯ, ҮХЯ |
| | | 13.3. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | ҮХЯ | |
| | | 13.4. Уул уурхайн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээ авах | ҮХЯ | |
| 14 | Эрүүл ахуйн шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүн амын хүнсний хангамжийг сайжруулах | 14.1. Хүнс тэжээлийн ач холбогдолтой ашигт ургамлыг тарималжуулах, таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх, үр суулгацыг өөрийн үйлдвэрлэлээр хангахад дэмжлэг үзүүлэх | ХХААЯ | ЭМЯ |
| | | 14.2. Иоджуулсан давс, амин дэм, эрдэс бодисоор баяжуулсан гурил, кальцжуулсан сүү зэрэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх | ХХААЯ | ЭМЯ |
| | | 14.3. Аймгийн төв болон хүн ам олноор төвлөрсөн газруудын хүн амын хэрэгцээг үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махаар хангахад дэмжлэг үзүүлэх | ХХААЯ | |
| | | 14.4. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдаж буй химийн бодисын нөлөөллийг хянах тогтолцоо, чадавхийг бий болгох | ХХААЯ | |
| | | 14.5. Экологийн цэвэр бүтээгдэхүүн Засгийн газрын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх | ХХААЯ | |
| | | 14.6. Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилт технологи нэвтрүүлэх | ХХААЯ | |
| | | 14.7. Сүү, цагаан идээг орон нутагт үйлдвэрлэлийн аргаар боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих | ХХААЯ | |
| | | 14.8. Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | ХХААЯ | |
| 15 | Хөдөө аж ахуйг эрчимтэй хөгжүүлж, үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, байгалийн аливаа эрсдэлээс хамгаалах, хөдөөд хүмүүс тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | 15.1. Малын даатгалын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар туршилтын төсөл хэрэгжүүлэх | ХХААЯ | СЯ, НХХЯ, ЗГХЭГ |
| | | 15.2. Усалгаатай талбайн хэмжээг ихэсгэх, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг үргэлжлүүлэх | ХХААЯ | |
| | | 15.3. Шүлхий өвчний оношлуур, вакцины туршилт, судалгаа хийх, дотооддоо үйлдвэрлэх бэлтгэлийг хангах | ХХААЯ | |
| 16 | "Цахим Монгол" хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлж, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | 16.1. Томоохон суурин газрууд, хотын захын гэр хороолол, дагуул хотуудын холбоожуулалтыг өргөтгөх, интернетийн сүлжээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлэх | МХХТГ | ЗТАЖЯ |
| | | 16.2. Утасгүй холбооны хамрах хүрээг дэвшүүлж хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх | МХХТГ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 16.3. Эрчим хүчний байнгын эх үүсвэртэй, хүн ам төвлөрсөн суурин газрын сургууль, айл өрхийг компьютержүүлж, интернетийн үйлчилгээний хүрээ, хүртээмжийг өргөжүүлэх | МХХТГ | |
| | | 16.4. Улиастай– Улаангом–Мөрөн- Өлгий, Дашинчилэн – Булган чиглэлд шилэн кабелийн сүлжээ байгуулах | МХХТГ | |
| | | 16.5. Зах зээлийн шаардлагад нийцүүлэн олон талт хэрэглээ бүхий иргэний бүртгэл мэдээллийн цогц систем бий болгох | МХХТГ | ХЗДХЯ |
| | | 16.6. Шуудангийн хаягийн системийг аймаг, нийслэлийн газар нутгийн байршил, хот төлөвлөлттэй уялдуулан боловсронгуй болгох | ЗТАЖЯ | ХЗДХЯ |
| | | 16.7. Төвийн бүсийн харилцаа, холбоо, мэдээллийн сүлжээг шинэчлэн сайжруулах | МХХТГ | |
| | | 16.8. Улаанбаатар хотын захын хороолол, Жаргалант, Гачуурт, Баянхошуу зэрэг алслагдсан газруудыг хөдөлгөөнт холбоо, телевизийн найдвартай сүлжээгээр хангах | МХХТГ | |
| | | Бүлэг 3. ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН САЛБАР | | |
| 17 | Амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэдийн хувийг бууруулах, | 17.1. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг өргөтгөх, бэхжүүлэх, тэдгээрт суралцагчдын тоог нэмэгдүүлэх замаар мэргэжилтэй ажиллах хүчний хангамжийг сайжруулах, улмаар хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх | БСШУЯ | НХХЯ, СЯ |
| | | 17.2. Цөөн малтай өрхийг малжуулах, залуу малчдыг мал маллагааны уламжлалт арга зүйд суралцуулах, байгаль, цаг уурын гэнэтийн таагүй үзэгдлийг даван туулах арга зүй эзэмшүүлэх замаар малчин өрхийн амьжиргааг дэмжих | ХХААЯ | НХХЯ, БОЯ |
| | | 17.3. Хөдөө, орон нутагт банк, санхүүгийн бүх төрлийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, харьцангуй бага хүүтэй гараанд зээл олгох асуудлыг судалж, хэрэгжүүлэх | Монгол банк | Санхүүгийн зохицуулах хороо, СЯ |
| | | 17.4. Алслагдсан аймаг, сумдын иргэдийн бараа, түүхий эдийг зах зээлд нийлүүлэх өртөг зардлыг хямдруулахад чиглэгдсэн зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах | ҮХЯ | ЗТАЖЯ |
| | | 17.5. Тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны ядуурлын түвшинд амьдарч байгаа иргэддээ түр болон тогтмол ажлын байранд зуучлах, мэргэжил олгох давтан сургалтад хамруулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх | Аймаг, нийслэлийн ЗДТГ | |
| | | 17.6. Ядуурлыг бууруулах чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөр, төслийн мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгох, ядуурал, ажилгүйдэл, орон гэргүй иргэдийн тоог бууруулах талаар бүх шатны Засаг дарга нарын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд тусгаж, үр дүнг тооцох механизмыг бүрдүүлэх | Бүх шатны ИТХ, ЗДТГ | |
| | | 17.7. Ядуу, нэн ядуу иргэдийн талаархи мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх ажлыг эхлэх | НХХЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 17.8. Амьжиргааг дээшлүүлэх, хөгжих нөхцөл боломжийг сайжруулах чиглэлээр залуучуудын идэвх санаачилгыг дэмжих, оролцоог хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх | НХХЯ | |
| 18 | Ажлын байрыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах | 18.1. "Ажлын байр" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх | НХХЯ | СЯ |
| | | 18.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгоход зориулсан жижиг зээл олголтыг өргөжүүлнэ | НХХЯ | БОЯ, ЗТАЖЯ |
| | | 18.3. Хөдөлмөрийн багтаамж ихтэй, нийтийг хамарсан ажилд ажилгүй байгаа иргэдийг хамруулах замаар түр ажлын байрыг бий болгох | НХХЯ | БОЯ, ЗТАЖЯ, БХБЯ |
| | | 18.4. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх замаар ажлын байр бий болгох | СЯ | НХХЯ, ЗТАЖЯ, БХБЯ |
| | | 18.5. Нийтийг хамарсан ажлыг байгаль орчныг хамгаалах болон ногоон сэргээх, зам барих, цөлжилттэй тэмцэх зэрэг хөдөлмөрийн багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт түлхүү зохион байгуулах | НХХЯ | БОЯ |
| | | 18.6. Хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа нэн ядуу, ядуу өрхийн зорилтот бүлгийг /урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтээр/ тодорхойлж тэдний хэрэгцээг хангахад хөдөөгийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг чиглүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах инкубаторын үйлчилгээг үзүүлэх | НХХЯ | ХХААЯ |
| | | 18.7. Бүсийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн бүсийн арга зүйн төв, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн боловсролын төвүүд бүхий мэргэжлийн боловсролын дэд бүтцийн үйл ажиллагааг орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангахад чиглэсэн хөдөлмөрийн зах зээлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх | НХХЯ | |
| | | 18.8. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгааг хийж, нийтэд мэдээлэх | НХХЯ | |
| | | 18.9. Улаанбаатар хотод хөдөлмөрийн бирж байгуулах ажлыг эхлүүлэх | НХХЯ | |
| | | 18.10. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангасан мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд шаардлагатай орчин үеийн сургалтын техник хэрэгслээр хангах | НХХЯ | БСШУЯ |
| | | 18.11. Хөдөлмөрийн харилцааны хамтын удирдлагыг хөгжүүлэх чиглэлээр Засгийн газар, МҮЭХ, МАОЭНХ-той хамтран нийгмийн түншлэл хөдөлмөрийн харилцааны асуудлаар дотоодын зөвлөгөөн, Үндэсний бага хурал зохион байгуулах | НХХЯ | |
| | | 18.12. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох | НХХЯ | ХЗДХЯ |
| | | 18.13. Сургалтын төрийн сангийн тогтолцоо, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгож, сургалтын зээлийн үр ашгийг дээшлүүлэх | БСШУЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 19 | Сургууль завсардалтыг бууруулж, бүх хүүхдэд бага боловсрол олгох зорилтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | 19.1. Эмзэг бүлгийн, бага орлоготой өрхийн болон 3 ба түүнээс дээш хүүхэд нь зэрэг сурдаг өрхийн нэг хүүхдэд хичээлийн хэрэгсэл үнэ төлбөргүй олгох арга хэмжээг үргэлжлүүлэх | БСШУЯ | |
| | | 19.2. Эмзэг бүлгийн болон бага орлоготой өрхийн суралцагчид сурах бичгийг эрхийн бичгээр олгох, асуудлыг шийдвэрлэх | БСШУЯ | |
| | | 19.3. Хөгжлийн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д суралцах боломжийг бүрдүүлэх үүднээс сургалтын тусгай хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх | БСШУЯ | |
| | | 19.4. Сумдын номын сангийн материаллаг баазыг бэхжүүлж, номоор хангах ажлыг сайжруулах | БСШУЯ | СЯ |
| 20 | Ерөнхий боловсролын сургалтыг 2005 оноос 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх | 20.1. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлж, ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлж, 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх бэлтгэлийг хангана | БСШУЯ | |
| | | 20.2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт мэргэжлийн баримжаа олгох сургалтыг оруулж мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж эхлэх | БСШУЯ | |
| 21 | Ерөнхий боловсролын сургуулийн суралцах орчин, нөхцөл, анги танхим, багш нарын болон сурах бичгийн хүрэлцээ, хангамжийг сайжруулах | 21.1. Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг зохион байгуулах замаар анги танхимын ачааллыг багасгах | БСШУЯ | |
| | | 21.2. Сурах бичгийг зохиох, хэвлэх, түгээх ажлыг хичээлийн жилийн өмнө зохион байгуулж, сурах бичгийн хүрэлцээ хангамжийг сайжруулах | БСШУЯ | |
| | | 21.3. Ерөнхий боловсролын сургуулиудыг сургалтын компьютерээр хангах арга хэмжээ авах | БСШУЯ | |
| 22 | Бага, дунд сургуульд элсэгчид болон бичиг үсэг тайлагдсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэнцвэргүй байдлыг багасгах | 22.1. Сургууль завсардсан хүүхэд, залуучууд болон насанд хүрэгчдийг бичиг үсэгт сургах ажлыг өргөжүүлж, боловсрол нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх | БСШУЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 23 | Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах | 23.1. Нялхсын хооллолтын үндэсний стратегийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, баталгаажуулах | ЭМЯ | |
| | | 23.2. Эхийн сүүг орлуулагч бүтээгдэхүүний кодын хуулийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн УИХ-д өргөн барих | ЭМЯ | ХЗДХЯ |
| | | 23.3. Ураг нярайн тусламж, үйлчилгээг сайжруулах стратеги боловсруулж, баталгаажуулах | ЭМЯ | |
| 24 | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, эхийн эндэгдлийг бууруулах | 24. 1. 2005-2010 онд эхийн эндэгдлийг бууруулах стратеги, төлөвлөгөө хэрэгжүүлэх | ЭМЯ | |
| | | 24.2. Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн тоног төхөөрөмжийг хандивлагч орнуудын тусламжтайгаар шинэчлэх арга хэмжээ авах | ЭМЯ | |
| | | 24.3. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн тэгсгөлийн үр дүнгийн үнэлгээ хийх | ЭМЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 25 | Сүрьеэ өвчний тархалтыг бууруулах | 25.1. Сүрьеэ болон бусад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | ЭМЯ | ХЗДХЯ |
| | | 25.2. Хорих байр болон урьдчилан хорих байрны багтаамж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах замаар сүрьеэ өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | ХЗДХЯ | ШШГЕГ |
| 26 | Төрийн болон хувийн өмчит эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулж, орчин үеийн иж бүрэн оношилгооны төвийг нийслэл болон бүсийн төвүүдэд байгуулах санаачилгыг дэмжих | 26.1. Нийгмийн салбарт хувьчлал хийх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | ЭМЯ | |
| | | 26.2. Гуравдахь шатлалын эмнэлэгт оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологи (MRI) нэвтрүүлэх талаар эхний шатны арга хэмжээг хэрэгжүүлэх | ЭМЯ | |
| | | 26.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэн шаардлагатай багц, нэмэлт багцыг сумдын эмнэлэгт хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулахын зэрэгцээ сумын эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх | ЭМЯ | |
| | | 26.4. Эрүүл мэндийн хөгжил–2 хөтөлбөрийн хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгийн болон сум, сум дундын эмнэлгийн барилга, тоног төхөөрөмжийг шинэчлэх | ЭМЯ | |
| | | 26.5. Клиникийн болон аймаг, сумдын эмнэлгийн лабораторийн чадавхийг нэмэгдүүлэх | ЭМЯ | |
| | | 26.6. Аймгийн төвөөс 207 км-ээс алслагдсан сумын эмнэлгийг нэн шаардлагатай багаж хэрэгслээр хангах | ЭМЯ | |
| | | 26.7. Дорнод аймгийн бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг гадаадын зээл, тусламжаар шинэчлэх | ЭМЯ | |
| 27 | Эмнэлгийн бүх түвшний удирдлагын чадавхийг сайжруулан, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах | 27.1. Нийгмийн эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн удирдлага, зохицуулалтыг сайжруулах | ЭМЯ | |
| | | 27.2. Эмнэлэг дундын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах асуудлыг үе шаттайгаар зохион байгуулж, эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцооны стратегийг хэрэгжүүлж эхлэх | ЭМЯ | |
| | | 27.3. Клиникийн 1,2 дугаар эмнэлэг болон Хавдар судлалын төвийн хооронд мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулан ажиллуулах | ЭМЯ | |
| | | 27.4. Түргэн тусламжийн машины парк шинэчлэл болон нөөн хангалтыг дэс дараатайгаар хэрэгжүүлэх | ЭМЯ | |
| | | 27.5. Түргэн тусламжийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох | ЭМЯ | |
| | | 27.6. Бүтээгдэхүүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог төлөвшүүлэх замаар санхүүгийн менежментийг боловсронгуй болгох | ЭМЯ | |
| | | 27.7. Эрүүл мэндийн эдийн засгийн сургалтыг зохион байгуулах замаар салбарын санхүүгийн удирдлагын чадавхийг сайжруулах | ЭМЯ | |
| | | 27.8. Төлбөртэй үйлчилгээтэй уялдуулан эмнэлгийн ажиллагсдын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | ЭМЯ | |
| | | 27.9. Азийн Хөгжлийн Банкны төсөл хэрэгжих Өвөрхангай, Завхан, Баянхонгор, Дорнод, Хэнтий аймгуудын сумын эмнэлгийг нэг иргэнээр тооцох санхүүжилтийн аргыг үргэлжлүүлэн турших | ЭМЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 27.10. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан санхүүжилтийн механизмыг боловсруулах | ЭМЯ | |
| | | 27.11. Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор дүүрэг, нэгдсэн эмнэлгүүдийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх | ЭМЯ | |
| | | 27.12. Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн менежментийг боловсронгуй болгох чиглэлээр төсөл хэрэгжүүлэх | ЭМЯ | |
| | | 27.13. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад үйлчилгээний хүртээмж, чанарын байдалд төрийн бус байгууллагууд, иргэдийн зүгээс тавих "нийгмийн хариуцлага"-ын тогтолцоог хэрэгжүүлж эхлэх | ЭМЯ | |
| | | 27.14. Анагаах ухааны эрдэм шинжилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгаа явуулах | ЭМЯ | БСШУЯ, СЯ |
| | | 27.15. Жилд нэг удаа хүн амын эрүүл мэндийн үзлэг хийх сан байгуулж, нийт хүн амыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах | ЭМЯ | |
| | | 27.16. 17 аймгийн 102 сумын төвийн ундны усыг цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулан хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах | БХБЯ | ЭМЯ |
| | | 27.17. Хүн амд эрүүл аж төрөх есыг төлөвшүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлыг бүх талаар дэмжиж, бүсийн төвүүдэд спортын цогцолбор, сумдад соёл, спортын төв барьж, үндэсний бөх, морь, сурын спортыг уламжлал, шинэчлэлийг хослуулан хөгжүүлэх санаачилгыг дэмжих | ЭМЯ | |
| 28 | Иргэдийн орон байрны хүрэлцээ,хангамж, нөхцөлийг мэдэгдэхүйц сайжруулж, гэр хорооллын дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 28.1. "40000 орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх | БХБЯ | СЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ |
| | | 28.2. Газрын харилцаа, хот байгуулалтын оновчтой бодлогыг тодорхойлон, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | БХБЯ | |
| | | 28.3. Төрийн ажилтан, албан хаагчдын орон сууцны дэд хөтөлбөр боловсруулж, төрийн төв байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | БХБЯ | СЯ, бусад яамд |
| | | 28.4. Улаанбаатар хотод ахмадын нийтийн орон сууц барьж, 200-гаас доошгүй ахмад настныг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах | Нийслэлийн ЗДТГ | БХБЯ |
| 29 | Хүн амын хэт төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч байгаа сөрөг үзэгдлийг багасгаж, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх | 29.1. Гэр хорооллын тодорхой зарим хэсэгт цэвэр, бохир усны шугам хоолой барьж байгуулах | БХБЯ | НХХЯ, ЭМЯ, БСШУЯ, ЗГХЭГ |
| | | 29.2. Гэр хорооллын хог хаягдал зайлуулах үйлчилгээг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх | БХБЯ | Нийслэлийн ЗДТГ |
| | | 29.3. Шилжин ирэгсдийн баримт бичгийн бүртгэл, шилжилтийн асуудлыг хөнгөн шуурхай, шат дамжлага багатай шийдвэрлэх арга хэмжээ авах | ХЗДХЯ | |
| | | 29.4. Шилжин ирэгсдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгаалал болон бусад ахуйн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах арга хэмжээг шуурхай, ээлж дараатай авч хэрэгжүүлэх | БХБЯ | ЭМЯ, БСШУЯ, НХХЯ |
| | | 29.5. Алслагдсан захын хорооллын иргэдийг эрчим хүчээр хангах асуудлыг шийдвэрлэх | БХБЯ | ТЭХЯ, Нийслэлийн ЗДТГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 29.6. Шилжин ирэгдийг бүртгэлд хамруулж, ажлын байраар хангах арга хэмжээ авах | БХБЯ | ХЗДХЯ, НХХЯ |
| | | 29.7. Улаанбаатар хотын мастер төлөвлөгөөнд нэмэлт тодотгол хийх | БХБЯ | Нийслэлийн ЗДТГ |
| | | 29.8. Мэргэжлийн сургалтын хөтөлбөр, стандартыг төгөлдөржүүлж, хөдөө орон нутагт хувийн хэвшлийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжих, тэдгээрийг шинээр байгуулах, өргөтгөх замаар мэргэжилтэй ажилчдын тоог 20 хувиар нэмэгдүүлэх | БСШУЯ | |
| 30 | Нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр "Нийгмийн хамгааллын салбарын стратегийн баримт бичиг"-т дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах | 30.1. Жирэмсэн, амаржсаны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж, даатгуулагчийн авч байсан цалин орлогын 100 хувьд хүргэх асуудлыг судалж, шийдвэрийн төсөл боловсруулах | НХХЯ | СЯ |
| | | 30.2. Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр "Хүүхдийн мөнгө хөтөлбөр"-ийн мэдээллийн сүлжээг бий болгох | НХХЯ | |
| | | 30.3. Нийгмийн халамжийн тухай шинэ хуулийг хэрэгжүүлэх заавар, журмуудыг боловсруулж, нийгмийн ажилтнуудын сургалт зохион байгуулах | НХХЯ | |
| | | 30.4. Асрамжийн газруудыг төрөлжсөн мэргэжлийн асрамжийн төв болгон өөрчлөх ажлыг эхлүүлэх | НХХЯ | |
| | | 30.5. "Хүүхдийн мөнгө" хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийж, амьжиргааны түвшин тогтоож буй аргачлалыг боловсронгуй болгох | НХХЯ | |
| | | 30.6. Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан бүсүүдийн төвүүдэд Нийгмийн үйлчилгээний төвүүдийг шинээр байгуулах асуудлыг судлах | НХХЯ | |
| | | 30.7. Шинээр гэр бүл болж буй хосуудад нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгож эхлэх | НХХЯ | СЯ |
| | | 30.8. Тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг ойртуулахад улсын төсвөөс 22.5 тэрбум төгрөгийг зарцуулж, тодорхой арга хэмжээ авах | НХХЯ | СЯ |
| | | Бүлэг 4. БАЙГАЛЬ ОРЧИН | | |
| 31 | Иргэд экологийн хувьд аюулгүй, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг хангах, хотуудын агаарын бохирдлыг багасгах | 31.1. "Агаарын чанарын алба" байгуулж төв суурин газрын агаарын бохирдлын хэмжээг тодорхойлж, агаарын бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээний стандартыг тогтоон мөрдүүлэх | БОЯ | ЭМЯ |
| | | 31.2. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор шахмал түлшний болон утаа багатай зуухны үйлдвэрлэлийг дэмжих | Нийслэлийн Засаг дарга | БОЯ, ТЭХЯ |
| | | 31.3. Томоохон хотуудын гэр хорооллыг утаа багатай шахмал түлш хэрэглэх хүрээг өргөтгөх | БОЯ | ТЭХЯ |
| | | 31.4. Авто тээврийн хэрэгслээс гарах хорт хийг хэмжиж бууруулах экологийн үнэлгээний стандарт, техникийн шаардлагыг тогтоон мөрдүүлж эхлэх | БОЯ | ЗТАЖЯ, Нийслэлийн ЗДТГ |
| | | 31.5. Уурхайнуудад жижиг оврын нүүрс цэвэршүүлэх технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх | БОЯ | ТЭХЯ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 31.6. Эрүүл ахуйн шаардлага хангасан хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулж, хатуу хог хаягдал цуглуулах, ангилах, ялгах, тээвэрлэх зохион байгуулалтыг боловсронгуй болгох | БОЯ | ЭМЯ, Нийслэлийн ЗДТГ |
| | | 31.7. Байгальд халгүй, сөрөг нөлөөлөл багатай технологийг судалж, нэвтрүүлэх, эрчим хүчний алдагдлыг багасгах, үр ашигтай хэрэглээг бий болгох, эрчим хүч, усны хэрэглээг тоолууржуулах ажлыг холбогдох салбар байгууллагаар зохион байгуулах | ТЭХЯ | БОЯ, ЗТАЖЯ, ҮХЯ |
| | | 31.8. Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах "Цагаан тоос" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх | БОЯ | ҮХЯ, Орхон аймгийн ЗДТГ |
| | | 31.9. Зарим сум, суурин газрын эрчим хүчний хангамжийг шийдвэрлэх зорилгоор нүүрсний хийгээр ажилладаг бага оврын цахилгаан станцыг барьж, туршилтын ажлыг эхлүүлэх | ТЭХЯ | СЯ, БОЯ, Нийслэлийн ЗДТГ |
| | | 31.10. Төв, суурин газрын агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утаагүй шахмал түлшний стандарт, техникийн нөхцөлийг боловсруулж мөрдөх | ТЭХЯ | БОЯ, Нийслэлийн ЗДТГ |
| | | 31.11. Иргэдийн эрүүл, аюулгүй, тохилог орчинд амьдрах нөхцөлийг нь хангах үүднээс ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн газрыг олгохыг хязгаарлах арга хэмжээ авах | БХБЯ | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 32 | Байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийн нөхөн сэргээлт, хамгааллыг сайжруулах | 32.1. "Цөлжилттэй тэмцэх", "Ногоон хэрэм" үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд говь, цөлийн бүсийн нөхцөлд илүү тохиромжтой модлог, сөөглөг, өвслөг ургамлын сонголт хийж, нийт 568 га талбайд шинээр ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулж, нутгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог урамшуулан өргөтгөх | БОЯ | |
| | | 32.2. Ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэлээр нь санхүүжүүлдэг журмыг нэвтрүүлж, ойн эзэмшил, хамгааллын эрх зүйн орчныг боловсронгуй болгох | БОЯ | УМХГ |
| | | 32.3. Мод, түлээ бэлтгэх, тээвэрлэх эрхийн бичиг болон гарал үүслийн гэрчилгээний хяналтын уялдаа холбоог хангаж, хууль бус аргаар мод бэлтгэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, тоноглолжийг эзний удаагийн үйлдлээр хураан улсын орлого болгон хариуцлага тооцдог эрх зүй, зохион байгуулалтын үндсийг бүрдүүлэх | БОЯ | ХЗДХЯ, УМХГ |
| | | 32.4. Байгальд ээлтэй арга, технологиор ашигт малтмалыг ашиглах ажлыг өргөжүүлж, уурхайн эдэлбэр газрыг холбогдох стандартын дагуу нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулах | БОЯ | ҮХЯ |
| | | 32.5. Махчин шувууд /идлэг шонхор/-ыг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглах эрх зүй, эдийн засгийн үндсийг бүрдүүлж, байгалийн популяцийг сэлбэх арга хэмжээ авах | БОЯ | ХЗДХЯ |
| | | 32.6. Нэн ховор, ховор ургамлын нөөц бүхий газар, баян бүрдүүдийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг эхлүүлэх | БОЯ | |
| | | 32.7. Агнуур зохион байгуулалтын судалгааны ажлыг тогтмолжуулах, цаашид агнуурын үйл ажиллагааг нөөцийн хэмжээнд үндэслэн тогтвортой | БОЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | удирдан зохицуулах | | |
| | | 32.8. Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлж, хамгаалалтын захиргаадын техник хэрэгслийн хангамж, хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх | БОЯ | Аймгуудын ЗДТГ |
| | | 32.9. Ногоон хэрэм экотрассын дагуу усны хайгуул судалгааны ажил гүйцэтгэж, уст цэг барих, усны хөв байгуулах замаар усны нөөц бий болгож, элсний нүүлтийг саармагжуулах туршилт хийх | БОЯ | ХХААЯ |
| | | 32.10. Байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийн талаар иргэдийн хариуцлага, эрх, үүргийг өндөржүүлэх, байгалийг байнгын эзэмшил, тордолт, хараа хяналттай болгон орон нутгийн хүн амд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх арга хэмжээ авах | БОЯ | |
| | | 32.11. Байгаль экологийн тэнцлийг хангахад онцгой ач холбогдол бүхий газруудыг тусгай хамгаалалтад авч, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх ажлыг эрчимжүүлэх | БОЯ | |
| | | 32.12. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, ялангуяа мазаалай зэрэг ховор, нэн ховор амьтныг хамгаалах, генфондыг нь хадгалах, өсгөн үржүүлэх арга хэмжээ авах | БОЯ | |
| | | 32.13. Ойжуулалтын ажлын цар хүрээг өргөжүүлж, арчилгаа, хамгаалалтыг сайжруулах, энэ чиглэлээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах | БОЯ | |
| | | 32.14. Гадаргын усны нөөцийг зохистой ашиглах, гол горхины тэжээгдлийг сайжруулах, усны хайгуул судалгааны ажлыг нэмэгдүүлэх, түүнчлэн худаг гаргах, засварлах ажлыг эрчимжүүлж, бэлчээрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | БОЯ | |
| 33 | Баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын эзлэх хувийг бууруулах; | 33.1. Цэвэр усны нөөц хомсдолтой говийн болон тал хээрийн бүсэд "Нөөцийн цөөцөлбөр" усан сан байгуулах үндэслэлийг тогтоох | БОЯ | ХХААЯ |
| | | 33.2. Хот, суурин газрын ундны усны үндсэн эх үүсвэр, тэдгээрийн чанар найрлагыг судлан тогтоох | БОЯ | ЭМЯ |
| | | 33.3. Томоохон хотын гэр хорооллын айл өрхийг усан хангамжийн төвлөрсөн системд холбох ажлыг өргөжүүлэх | БОЯ | БХБЯ<br>Нийслэлийн ЗДТГ |
| | | 33.4. Газрын доорхи усны горимын мониторингийн судалгааг бүсийн тулгуур төвүүдийн түвшинд эхлүүлэх | БОЯ | БХБЯ |
| | | 33.5. Усны нөөц, чанарын мэдээллийн сан байгуулж, усны хэрэглээ, ашиглалтын хяналтын системийг бүрдүүлэх | БОЯ | УМХГ |
| | | 33.6. Гол, горхины усны эхийг хамгаалан, нөхөн сэргээж, байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлж, гол, горхины усны эхийг бохирдуулж, нөөцийг нь хомсдуулж байгаа шалтгааныг тогтоон, ундны усыг ай савдар нь хамгаалж, нөхөн сэргээх зохицуулалтыг бий болгох | БОЯ | ХХААЯ<br>ЭМЯ |
| 34 | Байгаль, цаг уурын гамшигт үзэгдлээс ард иргэд, мал сүргийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | 34.1. Монгол улсын хэмжээнд бэлчээрийн даацыг шинэчлэн тодорхойлох, мал аж ахуйн хөгжлийн тулгуур бүсүүдийг тогтоох судалгааны ажлыг эхлүүлэх ба байгаль, цаг уурын өөрчлөлтөд зохицуулан бэлчээрийн мал аж | БОЯ | ХХААЯ<br>БСШУЯ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тогтолцоог сайжруулан, малчин өрх болон нийт эдийн засагт учирч байгаа хохирлыг бууруулах | ахуйг байршуулах оновчтой чиглэлийг тогтоох | | |
| | | 34.2. Цаг уурын урьдчилан сэргийлэх мэдээ гаргах шинэ арга зүй, технологийг боловсруулж турших | БОЯ | БСШУЯ |
| | | 34.3. Байгаль, цаг уурын гамшигт үзэгдлийг цаг тухайд нь үнэн зөв урьдчилан мэдээлж, сэрэмжлүүлэх ажлыг ард иргэдэд шуурхай хүргэн, хүн ам, эдийн засагт учирч болох хохирлыг бууруулах | БОЯ | |
| | | 34.4. Цаг агаарын мэдээг иргэдэд түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын чадавхийг дэмжин сайжруулах | БОЯ | ЗГХЭГ |
| | | Бүлэг 5. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙ, БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГО | | |
| 35 | Иргэд мэдээллийг чөлөөтэй олж авах эрх зүйн болон бусад боломж, нөхцлийг бүрдүүлэх | 35.1. Төсвийн үйл явц, ил тод байдлыг хангах хүрээнд иргэдийн төлөөллөөс бүрдсэн хяналтын баг ажиллуулан гүйцэтгэлийн тайланг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх | СЯ | ХЗДХЯ |
| | | 35.2. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний нэгдсэн сан бүрдүүлэх, улмаар иргэд, хуулийн этгээд ашиглахад ээлттэй, хялбар, хүртээлтэй болгох | ГХЯ | СЯ |
| | | 35.3. Төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарагдахаас бусад мэдээллийг иргэд чөлөөтэй үзэж танилцах боломжийг олгох эрх зүйн зохицуулалтыг сайжруулах арга хэмжээ авах | ХЗДХЯ | |
| | | 35.4. Боловсрол, эрүүл мэндийн салбарт нийгмийн хариуцлагын тогтолцоог нэвтрүүлж эхлэхтэй холбогдуулан тусламж үйлчилгээний мэдээллийг ил тод, хүртээмжтэй болгох | ЭМЯ, БСШУЯ | |
| 36 | Цэргийн шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлж, цэргийн байгууллагыг боловсронгуй болгон, зэвсэгт хүчний чадавхийг дээшлүүлэн, НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлэх | 36.1. Зэвсэгт хүчний анги салбарыг мэргэжлийн бие бүрэлдэхүүнээр хангах арга хэмжээг хэрэгжүүлж гэрээт цэргийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх | БХЯ | |
| | | 36.2. Дайчилгааны бэлтгэл нөөцийн 1, 2 дугаар зэргийн бэлтгэл болон бүх шатны удирдлагыг цэрэг-стратегийн, цэргийн бэлтгэл сургалтад хамруулах | БХЯ | |
| | | 36.3. Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрын алжаал тайлах, сувилах зардлыг төр хариуцах тогтолцоог бүрдүүлэх | БХЯ | |
| | | 36.4. НАТО-гийн "Энхийн төлөө түншлэл" хөтөлбөрийн хүрээнд НАТО-той хамтран ажиллах чиглэлийг гарган ажиллах | БХЯ | ХЗДХЯ, ГХЯ |
| | | 36.5. НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд оролцох зориулалт бүхий шинээр байгуулагдсан мотобуудлагын батальоныг үе шаттайгаар бэхжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авах | БХЯ | |
| | | 36.6. Цэргийн цагдаагийн 1 рот байгуулж, шаардагдах зэвсэг, техникээр хангаж, НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах бэлтгэлийг хангах | БХЯ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 37 | Хууль тогтоомж, стандартын биелэлтэд тавих мэргэжлийн хяналт, шалгалтыг чанаржуулж, иргэдэд үйлчлэх үйлчилгээний төрөл болгох | 37.1. Мэргэжлийн байгууллагын өнөөгийн чадавхи, түвшинд үнэлгээ хийх, мэргэжлийн хяналтын стратегийн бодлого, зорилтыг оновчтой тодорхойлон, чиг үүргийг хэрэгжүүлэх арга механизмыг улам боловсронгуй болгох чиглэлээр олон улсын байгууллага, гадаадын зөвлөхүүдтэй хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | УМХГ | |
| | | 37.2. Мэргэжлийн байгууллагаас олгож буй зөвшөөрөл, лицензийн судалгааг хийж, шаардлагатай дүрэм, журамд өөрчлөлт оруулах замаар үйлчилгээний шуурхай байдлыг хангах | УМХГ | |
| | | 37.3. Мэргэжлийн байгууллагаас тогтоосон стандартыг мөрдүүлэх ажлыг эрчимжүүлэх | УМХГ | |
| 38 | Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийг үнэн зөв шийдвэрлэн, хохирлыг барагдуулах, хууль хяналтын байгууллагыг бэхжүүлэх | 38.1. Сум болон нийслэлийн захын хороолуудад гэмт халдлагаас сэргийлэх зорилгоор хэсгийн төлөөлөгч ажиллах бичил хэсгүүдийг /"Кобон"/ байгуулах | ХЗДХЯ | |
| | | 38.2. Аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх | ХЗДХЯ | |
| | | 38.3. Аймаг, сумын цагдаагийн нэгжүүдийг хэт богино долгионы холбооны хэрэгслэл, автомашин, мотоциклоор хангах замаар үйл ажиллагааны шуурхай байдлыг сайжруулах | ХЗДХЯ | |
| | | 38.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс зарим зохион байгуулалтын арга хэмжээг авч, ажиллагсдын ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулан, тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх | ХЗДХЯ | |
| 39 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх улс төр, аюулгүй байдал, эрх зүйн гадаад таатай орчныг бүрдүүлэх | 39.1. Ази, Номхон далайн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхийн зэрэгцээ бүс нутаг, салбар бүсийн хэмжээнд өрнөж байгаа улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн олон талт үйл явц болон яриа хэлэлцээнд оролцож идэвхтэй үйл ажиллагаа явуулах | ГХЯ | ҮХЯ |
| | | 39.2. БНХАУ, ОХУ /ДХБ-д элссэний дараа/-тай чөлөөт худалдааны хэлэлцээ байгуулах чиглэлээр ажиллах | ГХЯ | ҮХЯ |
| | | 39.3. АСЕАН-ийн гишүүн орнуудтай хоёр талын харилцааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэх чиглэлээр ажиллах | ГХЯ | |
| | | 39.4. АСЕАН-ийн бүсийн чуулга уулзалт, Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх Зөвлөгөөн, Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ зэрэг бүс нутгийн олон талт үйл явцад гишүүн орны хувьд идэвхитэй оролцох | ГХЯ | |
| | | 39.5. Монгол, Европын Холбооны харилцааг түншлэлийн түвшинд гаргаж ахиулах, Европын Холбооны гишүүн орнуудтай хөгжүүлж ирсэн хоёр талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бататгахын зэрэгцээ хөгжлийн хамтын ажиллагааны хүрээг өргөтгөх чиглэл барин ажиллах | ГХЯ | ҮХЯ |
| | | 39.6. Өрнө, Дорнын өндөр хөгжилтэй бусад оронтой харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлж, тэдний бодит сонирхлыг Монгол Улсад бий болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, өндөр, дээд хэмжээний айлчлалыг | ГХЯ | ҮХЯ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх чиглэлээр ажиллах | | |
| | | 39.7. Хөнгөлөлтийн ерөнхий зарчимд бараа, бүтээгдэхүүн нэмж оруулах талаар АНУ, Япон болон бусад оронтой хийх хэлцлийг идэвхжүүлэх | ГХЯ | ҮХЯ |
| | | 39.8. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс Засгийн газар хоорондын комиссын үйл ажиллагааг идэвхжүүлэх | ГХЯ | ҮХЯ |
| | | 39.9. Монгол Улс НҮБ-д элссэний 45 жилийн ойг тэмдэглэх хүрээнд НҮБ, түүний системийн болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, хамтран ажиллах. НҮБ-ын зарим хөтөлбөр, сангуудтай хамтран ажиллах дунд хугацааны хөтөлбөрүүдийг тохиролцох | ГХЯ | |
| | | 39.10. НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох манай оролцоог өргөжүүлэх, улс төрийн ажиглагч оролцуулах, сургалт зохион байгуулах чиглэлээр ажиллах | ГХЯ | |
| | | 39.11. Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, 77-гийн бүлгийн үйл ажиллагаанд оролцож, хөгжиж буй орнуудын нийтлэг зорилго болон өөрийн орны үндэсний эрх ашигт нийцсэн асуудлаар хамтран ажиллах | ГХЯ | |
| | | 39.12. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын тавдугаар бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах | ГХЯ | |
| 40 | Иргэдэд тулгуурласан гамшгаас хамгаалах ажиллагааны менежментийн тогтолцоог бий болгож, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, гамшгаас хамгаалах хүч хэрэгслийг бэхжүүлэх | 40.1. Улс орны эдийн засагт нөлөөлөхүйц томоохон аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшиг, ослын үеийн урьдчилсан үнэлгээ хийх, найдвартай ажиллагааг хангах цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх | ОБЕГ | |
| | | 40.2. Улсын өөс, тэжээлийн нөөцийг хадгалах нөхцөлийг сайжруулах, нөөцийг бүрдүүлэх, түүний чанарыг сайжруулах, чанарыг уртасгах, үе шаттайгаар нөөцийг нэмэгдүүлэх | ОБЕГ | |
| | | 40.3. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын үед шаардагдах зарим материал, хэрэгслийн гамшгийн нөөцийг үе шаттайгаар бүрдүүлэх, аймаг, сумдад байвал зохих нөөцийн жагсаалтыг гарган байнгын нөөцтэй байлгах арга хэмжээ авч, эрх зүй, санхүүгийн орчинг боловсронгуй болгох | ОБЕГ | |
| | | 40.4. Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хяналт, зохицуулалтын механизмыг сайжруулах | ОБЕГ | |
| 41 | Гамшгаас хамгаалах боловсролыг иргэдэд олгох, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх | 41.1. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан явуулах арга хэлбэрийг боловсронгуй болгон, иргэдийг аюулгүй амьдрах арга, ухаанд сургах ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулах | ОБЕГ | |
| | | 41.2. Гамшгаас хамгаалах салбарт мэргэжилтэн бэлтгэх, тэдгээрийг давтан болон ажлын байран дээр нь сургах | ОБЕГ | |
| | | 41.3. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлэн байдлын сургалтад агуулга, стандартын өөрчлөлт хийж, гамшигтай тэмцэх арга техникт сургах цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх | ОБЕГ | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 42 | Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх | 42.1. Залуучууд-эмэгтэйчүүд,шинэ үеийнхний удирдлагад бэлтгэх сургалтыг улс төрийн намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтран зохион байгуулах | НХХЯ | НХХЯ |
| | | 42.2. Олон нийтийн дунд сонгуулийн тухай хуулийг төрийн бус байгууллага болон хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоотойгоор сурталчлах | ХЗДХЯ | |
| 43 | Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв болон бусад албадын мэдээлэл солилцох хүчин чадлыг нэмэгдүүлэх, иргэдэд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй болгох | 43.1. Хилийн чанадад суугаа Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хөндсөн иргэний бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдсон хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг судлан санал боловсруулах | ХЗДХЯ | ГХЯ |
| | | 43.2. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн "ВЭБ" сайтыг нээлттэй ажиллуулж, иргэний бүртгэлийн чиглэлээр гадаадад амьдарч байгаа иргэдийн эрх ашгийг хөндсөн бэрхшээлтэй байгаа асуудлаар санал авч судлан холбогдох асуудлын талаархи зааварчилгааг интернетээр өгч хэвших | ХЗДХЯ | |
| | | 43.3. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, иргэний бүртгэл, мэдээллийн албадын мэдээлэл солилцох хүчин чадлыг нэмэгдүүлэх | ХЗДХЯ | |
| 44 | "Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн хүрээнд хууль болон эрх зүйн үйлчилгээг хэрэглэгчдэд хүртээмжтэй, хөнгөн шуурхай болгох | 44.1. Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох ажлын хүрээнд хотын статусыг бий болгож, хөдөөд төвлөрөл бий болгох арга хэмжээг авах | БХБЯ | ХЗДХЯ, ЗГХЭГ, Аймгуудын Засаг дарга нар |
| | | 44.2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг өөрчлөхтэй уялдуулан орон нутагт хүн амын зохистой төвлөрлийг дэмжих үүднээс зэргэлдээ аймаг, сумын төвтэй ойрхон, нэн тэргүүнд татан буулгаж нэгтгэх боломжтой хүн ам цөөн, газар нутаг багатай хэт жижиг сумдын судалгааг гаргаж, хэлэлцүүлэх | БХБЯ | ХЗДХЯ, ЗГХЭГ, Аймгуудын Засаг дарга нар |
| | | 44.3. Сайн засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлж, яам, агентлагийн бүтэц, орон тоог хянаж, удирдлагын зардлыг хямдруулах | ЗГХЭГ | |
| | | 44.4. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагын, ялангуяа сумдын Засаг даргын Тамгын газрын байрыг засварлаж, төрийн албан хаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулах | ЗГХЭГ | |
| 45 | "Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл"-д тусгагдсан зорилтыг хэрэгжүүлж, төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн газруудыг цаашид улсын эдийн засагт илүү хувь нэмэр оруулахуйц байдлаар хувьчилж, өөрчлөн байгуулах | 45.1. Хувьчлалын арга хэлбэрийг өргөтгөн, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж, төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн газруудыг улсын эдийн засагт илүү хувь нэмэр оруулахуйц байдлаар хувьчлах | ЗГХЭГ | |

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 2/04 | Улаанбаатар хот

**Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, Л.Рэнчин, П.Очирбат, Д.Наранчимэг /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хүсэлт гаргагч Улсын Дээд шүүхийг төлөөлж Улсын Дээд шүүхийн Иргэний танхимын тэргүүн шүүгч Ц.Амарсайхан, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд нар оролцов.

Нэг. Монгол Улсын Дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд мэдүүлсэн хүсэлтдээ: "Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль 2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль гарч, Иргэний хуульд 154.3, 154.4, 174.3, 174.4 гэсэн хэсгүүдийг нэмж, 171 дүгээр зүйлийн 171.3, 174 дүгээр зүйлийн 174.2, 453 дугаар зүйлийн 453.2-т үг, өгүүлбэрүүд нэмжээ.

Иргэний хуульд орсон дээрх нэмэлт, өөрчлөлтүүдийн зарим нь утга агуулгаараа иргэний эрх зүйн үндсэн ойлголт, зарчмыг үгүйсгэн зөрчсөнөөс гадна Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байна гэж Улсын Дээд шүүх үзэж, энэ талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлэх тухай тогтоол гаргасан. /Улсын Дээд шүүхийн 2006 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоол/.

Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуультай нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргуулахаар Улсын Дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлж байна.

1.Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-т "барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэж заасан нь утга агуулгаараа ойлгомжгүй бөгөөд өмчлөгчийн эрхийг зөрчсөн гэж үзэж байна.

Аливаа хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч нь бусдын гүйцэтгэх үүрэгт өөрийн өмчлөлийн зүйлийг барьцаалж болно, гэхдээ үүний тулд өмчлөх эрхээ тэрхүү үүрэг гүйцэтгэгчид шилжүүл гэсэн утгатай зохицуулалт болжээ.

Өмчлөх эрх нь тухайн эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах хэлбэрээр хэрэгждэг билээ. Өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг барьцаалах эрх нь эд хөрөнгө захиран зарцуулах эрхийн нэг хэлбэр мөн. Гэтэл хуулийн энэхүү заалтаар өмчлөгч нь өмчлөх эрхээ захиран зарцуулах хэлбэрээр хэрэгжүүлэхийн тулд өмчлөх эрхээсээ татгалзах ёстой гэсэн утгатай зохицуулалт харагдаж байна.

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дугаар хэсэгт заасан Монгол Улсын иргэн "хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй" гэсэнтэй нийцэхгүй байна гэж Улсын Дээд шүүх үзэж байна.

2.Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.4-т "барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэж заасан нь утгын алдаатайгаас гадна Үндсэн хуулийн дээрх заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

Ирээдүйд бий болох эд хөрөнгийг барьцаалж болохоор хуульчилсан атлаа энэхүү эд хөрөнгийг бий болсон үед л барьцаална гэсэн утгын зөрчил нь хуулийн энэ заалтыг хэрэглэхэд хүндрэл үүсгэж болзошгүй байгаагаас гадна өмчлөгч өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг барьцаалах хэлбэрээр захиран зарцуулж, өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг хүсвэл өмчлөх эрхээсээ татгалзаж, бусдад

шилжүүлэх шаардлагатай болж байгаа тул хуулийн энэ заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дугаар хэсэгт заасан "хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй" гэсэн Монгол Улсын иргэний үндсэн эрхүүдийн нэгийг зөрчсөн гэж үзэж байна.

3.Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т "үүрэг гүйцэтгэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана" гэсэн нь нэгдүгээрт иргэний эрх зүйн талуудын тэгш эрхийн зарчим, хоёрдугаарт, "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан зарчим, гуравдугаарт, Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан "шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно", дөрөвдүгээрт, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дүгээр хэсэг буюу "эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Барьцааны гэрээний харилцаа бол иргэний эрх зүйн харилцаа мөн бөгөөд барьцаалагч этгээд иргэн, хуулийн этгээдийн алин ч байсан адил зарчим үйлчилдэг билээ. Гэтэл хуулийн энэхүү заалтаар барьцаалагч нь банк, банк бус санхүүгийн байгууллага байвал өөр зарчим үйлчилснээр "...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан зарчим хөндөгдөж байна. Иргэн Б хөрөнгө чинээ ихтэй тул банк бус санхүүгийн байгууллага ажиллуулах боломжтой болжээ, иргэн А их хэмжээний хөрөнгөгүй. Хэн алин нь бусдад мөнгө зээлдүүлэх эрхтэй ба зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангах зорилгоор бусдын эд хөрөнгийг барьцаалах эрхтэй. Хэн алин нь Иргэний хуульд зааснаар зээлийн болон барьцааны гэрээ байгуулна. Гагцхүү банк бус санхүүгийн байгууллага ажиллуулдаг Б барьцааны эд хөрөнгөнөөс өөрийн шаардлагыг шүүхийн ч, шүүхийн бус ч журмаар хангуулах боломжтой бол хөрөнгө чинээ нь арай дутмаг А зөвхөн шүүхийн журмаар шаардлагаа хангуулах боломжтой байна. Ингэснээр хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх Үндсэн хуулийн зарчим хэрэгжих боломжгүй болж байна.

Нөгөө талаар, банк болон банк бус санхүүгийн байгууллага нь барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах шаардлагатай болсон тохиолдолд шүүхэд ч, бүртгэлийн байгууллагад ч хандах эрхтэйгээр хуульд заасан нь шүүхийн шийдвэрлэх тодорхой нэг ижил асуудлыг бүртгэлийн байгууллага адилхан шийдвэрлэх боломжтой гэсэн утгатай болжээ.

Шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэх явдал нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй нэг хэлбэр билээ. Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан "шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн зарчим дээрх хуулийн заалттай буюу шүүхийн шийдвэрлэх асуудлыг бүртгэлийн байгууллага мөн л адил шийдвэрлэдэг зохицуулалттай илтэд нийцэхгүй байна. Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2 дахь заалт буюу "...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэсэн заалтыг Иргэний хуулийн дээрх заалт зөрчсөн гэж Улсын Дээд шүүх үзнэ.

Түүнчлэн, банк, банк бус санхүүгийн байгууллага нь шүүхийн бус журмаар ипотекийн зүйлийг худалдан борлуулахаар бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргахад эд хөрөнгийн өмчлөгч энэхүү ажиллагаа, эд хөрөнгийн үнэлгээ зэрэг асуудлаар эрх нь зөрчигдлөө гэж үзвэл хаана хандах вэ? Ипотекийн шаардлага бүхий этгээд болох банк, банк бус санхүүгийн байгууллага л шүүхийн бус журмыг сонгосон бол иргэний эрх зүйн тухайн харилцаанд тэгш эрхийн зарчмаар оролцож буй өмчлөгчийн шүүхэд хандах эрх хаагдах ёстой гэж хэрхэвч үзэж болохгүй гэдэг нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дүгээр хэсэгт тов тодорхой туссан байна. "Эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх"-ээр Монгол Улсын иргэнд Үндсэн хуулиар олгогдсон эрх иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нөгөө талын хүсэлт зоригоор биелэлээ олж чадахгүй байх боломжийг бүрдүүлсэн хуулийн дээрх заалт Үндсэн хуультай нийцэхгүй байна.

4.Хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3 "ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй", 174 дүгээр зүйлийн 174.2-т "барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй" гэсэн нь дээр дурдсан үндэслэлүүдээр Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт буюу "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14 дүгээр хэсэг буюу "эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй" гэсэнтэй нийцэхгүй байна.

Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т "үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ" гэж зааснаар тухайн хэм хэмжээний үндсэн агуулгыг тодорхойлсон бөгөөд барьцаалагдсан үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулахад өөр журам хуулиар тогтоохыг хязгаарлаж, өөр журам тогтоосон тохиолдолд ч Иргэний хуулийн зохицуулалтыг даган мөрдөхийг заасан байхад зарчмын ач холбогдолтой энэ өгүүлбэрийн дараа "энэ заалт банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллагад хамаарахгүй" гэж нэмсэн нь Иргэний хуулийн тухайн зохицуулалтын утгыг алдагдуулж, иргэний эрх зүйн харилцааны оролцогч хуулийн этгээдэд хуулиас гадуур, бусдаас илүү эрх олгож буй нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалт буюу "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн зарчимтай нийцэхгүй байна гэж Улсын Дээд шүүх үзэж байна.

Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.3, 174.2-ын хоёр дахь өгүүлбэр нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү" гэжээ.

Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн З.Энхболд тайлбартаа:

1.Улсын Дээд шүүх Иргэний хуулийн 154.3 дахь хэсгийн заалт нь "...бусдын гүйцэтгэх үүргэг өөрийн өмчлөлийн зүйлийг барьцаалж болно, гэхдээ түүний тулд өмчлөх эрхээ тэрхүү үүрэг гүйцэтгэгчид шилжүүл гэсэн утгатай зохицуулалт болжээ. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Монгол Улсын иргэн "хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхтэй" гэсэнтэй нийцэхгүй байна" гэжээ.

Энэ зохицуулалт нь хэн нэг гуравдагч этгээд бусдын гүйцэтгэх үүргэг өөрийн хөрөнгийг барьцаалах асуудал биш юм. Улсын Дээд шүүхийн ойлгож буй тохиолдлын хувьд гуравдагч этгээд өөрөө барьцаалагчтай /өөрийн нэрийн өмнөөс/ гэрээ байгуулахаас биш үндсэн үүрэг гүйцэтгэгч түүний хөрөнгөөр барьцаалагчтай барьцааны гэрээ байгуулахгүй.

Энэ заалтын агуулга нь хэн нэг барьцаалах хөрөнгөгүй иргэн орон сууц авах зорилгоор зээл авахыг хүсчээ гэвэл /барьцааны гэрээ байгуулах үед барьцааны хөрөнгөгүй байсан ч/ уг зээлээр худалдан авах сууцаа эргүүлэн барьцаа болгох зохицуулалт юм.

Нэгэнт барьцаа нь талууд харилцан тохиролцох замаар байгуулдаг үүргийн эрх зүйн харилцаа тул барьцааны ямар зүйлийг хүлээн зөвшөөрөх нь барьцаалагчийн эрсдэлийн асуудал гэж үзнэ. Иймд "Барьцааны зүйл бусдын өмчлөлийн эд хөрөнгө байж болно" гэдгийг хэн нэгний хөрөнгийг өмчлөлдөө шилжүүлсний дараа барьцаал гэж биш, харин тухайн гэрээний үр дүнд, ирээдүйд өмчлөлдөө шилжүүлэх хөрөнгөө эргүүлэн барьцаанд тавьж болно гэсэн агуулгаар ойлгох нь зүйтэй.

Нөгөөтэйгүүр, барьцаалагчийн шаардах эрх нь гагцхүү барьцаалуулагчид өмчлөх эрх бий болсноор хэрэгжихээр заасан нь бусад өмчлөгчдийн эрхийг хөндсөн бус, эсрэгээр хамгаалсан зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, өмчтэй болно гэсэн амлалт биелүүлээгүйн төлөөх эрсдэлийг барьцаалагч /барьцааны зүйлийг хүлээн зөвшөөрсний хувиар/ хүлээх ба хэн нэгний өмчид халдахгүй гэсэн үг юм.

2.Иргэний хуулийн 154.4 дэх хэсэг нь дээрх заалттай агуулгын хувьд төстэй юм. Дээр тайлбарласанчлан ирээдүйд өмчлөлдөө бий болгох /барьцааны гэрээ байгуулах үед барьцаалуулагчийн өмчлөлд байхгүй/ хөрөнгийг барьцаалах боломжийг нээж өгч байгаа юм. Энэ нь бусдын өмчлөх эрхийг мөн дээрхийн адил хөндөхгүй.

Учир нь шаардах эрх нь Иргэний хуулийн 154.3 дахь хэсгийн мөн адил тухайн ирээдүйд бий болох хөрөнгө нь бий болж, үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлд шилжсэн нөхцөлд үүснэ. Үүнд тодруулбал, хэдийгээр ирээдүйд бий болох хөрөнгө бий болсон боловч барьцаалуулагчийн өмчлөлд шилжээгүй бол шаардах эрх нээгдэх боломжгүй байгаа. Ингэснээр бусад хууль ёсны өмчлөгчдийн эрх мөн адил хамгаалагдаж байгаа юм.

3.Иргэний хуулийн 174.2 дахь хэсгийн "Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй" гэсэн 2 дахь өгүүлбэр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэж заасныг зөрчсөн байна гэжээ.

Тэгш эрхийн зарчим нь гагцхүү ижил тэгш субъектуудын хооронд л яригддаг. Өөрөөр хэлбэл, ижил биш талуудын хооронд тэгш эрхийн асуудал хэзээ ч яригддаггүй. Жишээлбэл, банк болон банк бус санхүүгийн байгууллага аль аль нь иргэний эрх зүйн субъектууд боловч эрх зүйн статусын хувьд өөр өөр бөгөөд үүнтэй холбогдуулан өөр өөр эрх

эдэлж, үүрэг хүлээдэг. Банк хадгаламжийн үйл ажиллагаа явуулах эрхтэй байхад банк бус санхүүгийн байгууллага хадгаламжийн үйл ажиллагаа явуулах эрхгүй байдаг гэх мэт. Хэрэв бүх этгээдүүд тэгш эрхтэй байдаг гэж үзвэл банк, банк бус санхүүгийн байгууллага, компани, төрийн бус байгууллага, цаашилбал, иргэн хүртэл хадгаламжийн үйл ажиллагаа явуулах эрх нь нээлттэй байх ёстой нь дамжиггүй юм.

4.Иргэний хуулийн 174.3 дахь хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-ын "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14-ийн "эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх эрхтэй", Дөчин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна гэжээ.

Бүртгэлийн байгууллага нь барьцааны зүйлийг худалдан борлуулах эсэх асуудлыг шийддэг, шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага огтхон ч биш юм. Харин хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүхийн бус журмаар аливаа этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, нөгөө этгээдэд учруулсан хохирлыг тогтоох, түүнийг гаргуулах, талуудын хоорондын маргааныг шийдвэрлэх зэрэгтэй холбоогүй бөгөөд гагцхүү тухайн барьцаалсан үл хөдлөх хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулж байгааг, ийнхүү хангуулах ажиллагаа нь хуульд заасан процедурын дагуу явагдаж байгаа гэдгийг л гэрчлэн бүртгэж буй үйлдэл юм.

Уг ажиллагааны нэг онцлог нь ажиллагаанд оролцогч талууд аливаа хэлбэрээр маргаан гаргаагүй байх ёстой. Хэрэв талуудын аль нэг нь гэрээний талаар, эсхүл ажиллагааны явцад эрх нь зөрчигдсөн гэж үзэн маргаан үүсгэсэн тохиолдолд уг асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Хэдийгээр Иргэний хуулийн 174.3 дахь хэсэгт заасны дагуу асуудлыг шүүхийн бус журмаар шийдвэрлэх ч шүүхийн бус шатанд шийдвэрлэх явцад хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагааны аль ч шатанд, хэдийд ч шүүхэд хандан зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжтой юм. Энэ нь Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан боруулах журмын тухай хуулийн 27.1 дэх хэсэгт заасан байгаа. Түүнчлэн нэгэнт хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрх нь нээлттэй байна.

Иймээс Иргэний хуулийн 174.3 дахь хэсгийн заалт нь хэн нэгнийг шүүхэд хандахаас хязгаарлах бус, гагцхүү аливаа этгээдийн эрх, эрх чөлөө нь зөрчигдөөгүй тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг шүүхийн оролцоогүйгээр хангуулах эрх зүйн үндсийг бий болгож өгсөн шинжтэй заалт юм.

Иймд Иргэний хуулийн 154 дүгээр зүйлитйн 154.3, 154.4 дэх хэсэг, 174 дүгээр зүйлийн 174.3 дахь хэсэг, 174.2 дахь хэсгийн хоёрдахь өгүүлбэр Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна" гэжээ.

Гурав. Улсын Дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд 2006 оны 4 дүгээр сарын 11-ны өдөр ирүүлсэн нэмэлт тайлбартаа:

"1.Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4-т туссан зохицуулалтын талаар.

Зах зээлийн эдийн засгийн үед барьцааны гэрээний төрлүүдээс маш чухал ач холбогдолтой төрлийг Улсын Их Хурлын төлөөлөгч тайлбартаа дурдсан байгааг юуны өмнө нь тэмдэглэх нь зүйтэй байна. Энэ нь ирээдүйд өөрийн өмчлөлд ирэх үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах асуудал юм. Энэ төрлийн барьцаа нь:

А.Бодит байдалд бий болчихсон боловч барьцаалуулагчийн өмчлөлд хараахан шилжиж ирээгүй, энэхүү барьцаагаар хангагдах үүргийн үр дүнд өмчлөлд нь шилжих бодит боломж бүрдсэн үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа юм. Орон сууц худалдан авах хүсэлтэй этгээд бусдаас зээл авахдаа худалдах-худалдан авах гэрээний дагуу өмчлөлд нь шилжиж ирэх орон сууцыг өмчлөлдөө шилжээгүй буюу бусдын өмчлөлд байхад нь тухайн зээлийн үүрэгт барьцаалдаг.

Б.Бодит байдлаар бий болоогүй хэдий ч барьцаагаар хангагдах үүргийн дагуу олж авсан хөрөнгөөр ирээдүйд бий болгох үл хөдлөх эд хөрөнгийг уг эд хөрөнгийг бий болгох зорилгоор хүлээж буй үүрэгт барьцаалах. Байшин барилга барих хүсэлтэй этгээд энэ хүслээ биелүүлэхийн тулд бусдаас мөнгө зээлж авахдаа ирээдүйд бий болох, одоогоор бий болоогүй, өмчлөх эрх нь үүсээгүй үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалдаг.

Дээрх хоёр төрлийн барьцааны талаар Иргэний хуульд огт тусгагдаагүй биш харин бүдэг тусгагдсан гэж үзэхээр байна. Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.3-т "барьцаа үүсэх үед

тодорхойлж болох, ирээдүйд бий болох, болзол тавьсан шаардлагыг хангахад барьцааг хэрэглэж болно" гэж заасныг зөвхөн барьцаагаар хангагдах шаардлагад биш харин барьцааны зүйлд хамааруулж ойлгох боломжтой юм. Өөрөөр хэлбэл, одоогоор өмчлөх эрх нь үүсээгүй хэдий ч ирээдүйд үүсэх боломжтой нь тодорхой болсон эд хөрөнгийн талаар өмчлөх эрх үүссэн тохиолдолд барьцааны шаардах эрх үүсэхээр болзол тавьсан барьцааны гэрээ байгуулж болохоор тусгагдсан байна.

Энэ заалтыг илүү дэлгэрэнгүй болгох нь чухал ач холбогдолтой хэдий ч Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4-т оруулсан нэмэлтүүд нь дээр дурдсан харилцааг харамсалтай нь зохицуулж чадаагүй байна. Хуульд тусгагдсан одоогийн хэлбэр нь барьцааны гэрээний онцлог төрлийг тодотгож өгөөгүйгээс гадна харин бүр барьцааны гэрээний энгийн хэлбэрийг ч ойлгомжгүй болгосон байна. Үүнийг доорхи үндэслэлээр тайлбарлаж байна.

1.1.Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.3-т "барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэснийг үгийн шууд утгаар нь тайлбарлахад "барьцааны зүйл болох эд хөрөнгө нь бусдын өмчлөлд байгаа хэдий ч ирээдүйд барьцаалуулагчийн өмчлөлд шилжих бодит боломжоо бүрдсэн тохиолдолд барьцааны зүйл байж болно. Энэ тохиолдолд өмчлөх эрх барьцаалуулагчид шилжсэнээр барьцааны эрх үүснэ" гэж ойлгогдохгүй байна. Ямар нэгэн тодотголгүйгээр бусдын өмчлөлийн зүйлийг барьцаалж болно гэж тусгаж орхисноор тухайн эд хөрөнгийн өмчлөгчийн эрхийг зөрчөөгүй гэж үзэх үндэслэл харагдахгүй байна. Энд тухайн өмчлөгчийн хүсэл зоригийн илэрхийлэл биш юмаа гэхэд ядаж зөвшөөрөл байх тухай чухал заалт огт хэрэггүй мэт орхигджээ.

1.2.Барьцааны зүйл ирээдүйд барьцаалуулагчийн өмчлөлд шилжих боломжтой байх нь бусдын өмчлөлийн эд хөрөнгийг барьцаалах цорын ганц тохиолдол биш юм. Барьцааны эд хөрөнгийн өмчлөгч, барьцаагаар хангагдах шаардлагыг биелүүлэх ёстой үүрэг гүйцэтгэгч хоёр өөр этгээд байх тохиолдол нь барьцааны гэрээгээр үүрэг үүсэх хамгийн түгээмэл тохиолдол билээ. "Барьцааны зүйл бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно" гэсэн зохицуулалт энэ тохиолдолд хамааралгүй гэж үзэх үндэслэл байхгүй байна. Энэ утгаар нь өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг бусдын үүргийг барьцаалах хэлбэрээр захиран зарцуулахыг хүсвэл өмчлөх эрхээсээ татгалзаж, үүрэг гүйцэтгэгчийг барьцаалуулагч болго гэсэн утга санаатай болсон хуулийн зохицуулалтыг Улсын Дээд шүүх Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө ...өмчлөх эрхтэй" гэсэн Монгол Улсын иргэний үндсэн эрхийг зөрчсөн гэж үзсэн юм.

1.3.Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-д "үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно" гэж заасны үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжих асуудал зохицуулагдсан байна. Өмчлөх эрх шилжинэ гэдэг нь хэн нэгэнд үүсчихсэн өмчлөх эрх ямар нэгэн хэлцлийн үндсэн дээр бусдад шилжихийг хэлдэг байх. Гэтэл Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.4-т "барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэсэн зохицуулалтыг өмчлөх эрх шинээр үүсэх тохиолдолд хамааруулж ойлгох нь учир дутагдалтай байна. Өөртөө барилга, байшин барих хүсэлтэй этгээд зээл авахдаа энэ мөнгөөр барих үл хөдлөх эд хөрөнгөө барьцаалж болно. Энэ тохиолдолд шинээр бий болсон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх үүсэх асуудал яригдахаас биш өмчлөх эрх шилжих асуудал тавигдахгүй юм. Энэ утгаараа ирээдүйд бий болох тухайн эд хөрөнгө мөн л үүрэг гүйцэтгэгчийнх биш харин түүний хүлээх үүргийг ирээдүйд бий болох өөрийн эд хөрөнгийг барьцаалсан гуравдагч этгээдийн өмчлөлийн эд хөрөнгө байхаар харагдаж байна. Тийм ч учраас өөрийн ирээдүйд бий болох эд хөрөнгийг бусдын гүйцэтгэх үүргийг барьцаалах хэлбэрээр захиран зарцуулсан этгээд өмчлөх эрхээсээ татгалзаж, үүрэг гүйцэтгэгчийг барьцаалагч болго гэсэн утга санаа байна гэж Улсын Дээд шүүх үзсэн юм.

1.4.Барьцааны эрхийн зохицуулалт нь Иргэний хуулийн 13 дугаар бүлэгт тусгагдсан ба энэ бүлэг нь гурван дэд бүлгээс бүрдэж байна. Нэгдүгээр дэд бүлэгт барьцааны нийтлэг зохицуулалт, хоёрдугаар дэд бүлэгт хөдлөх эд хөрөнгийн болон эрхийн барьцааны тусгай зохицуулалт, гуравдугаар дэд бүлэгт үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа /ипотек/-наас үүсэх харилцаа тус тус зохицуулагдсан байна. Барьцааны нийтлэг зохицуулалт нь хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн болон эрхийн барьцааны хувьд адил үйлчлэх бөгөөд

тухайн дэд бүлгүүдэд тусгайлсан зохицуулалт байхгүй бол нэгдүгээр дэд бүлэгт туссан нийтлэг зохицуулалт үйлчилдэг билээ. Гэтэл бусдын өмчлөлд одоогоор байгаа боловч ирээдүйд үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлд шилжих бодит боломжоо бүрдсэн барьцааны зүйл нь ирээдүйд бий болох эд хөрөнгө ч мөн адил зөвхөн үл хөдлөх эд хөрөнгөнд хамааралтай юм. Учир нь эд хөрөнгө худалдах-худалдан авах гэрээг улсын бүртгэлд бүртгүүлэхийн зэрэгцээ барьцааны гэрээг ч бүртгүүлэх боломжтой болдог ба улсын бүртгэл нь үүрэг гүйцэтгүүлэгч буюу барьцаалагчийн хувьд шаардах эрхийн гол үндэслэл болдог. Хөдлөх эд хөрөнгийн хувьд болон эрхийн барьцаанд дээрх тохиолдол хамаардаггүй байхад хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө болон эрхийн барьцааны алинд ч хамааралтай нийтлэг зохицуулалтын хэсэгт тухайн зохицуулалт орох боломжгүй юм.

2.Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т туссан "үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ" гэсэн заалт банк болон банк бус санхүүгийн байгууллагын хувьд хамаарахгүй байхаар Иргэний хуульд нэмэлт оруулсныг Улсын Дээд шүүх Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш" байх зарчмыг зөрчсөн гэж үзэж, тайлбар гаргахдаа иргэн болон банк, банк бус санхүүгийн байгууллагын эрх зүйн ерөнхий байдлыг ижил гэж үзээгүй болно.

Банк, банк бус санхүүгийн байгууллага нь иргэдээс эрх зүйн байдлаар өөр болох нь хэнд ч ойлгомжтой зүйл юм. Түүгээр ч зогсохгүй зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан үүрэг бүхий этгээдийн хувьд эдгээр байгууллагуудаас зээл олгох харилцааг иргэд хоорондын болон бусад хуулийн этгээд хоорондын зээлийн харилцааг зохицуулснаас өөрөөр зохицуулдаг билээ.

Гагцхүү аливаа хуульд, тухайлбал, Иргэний хуульд зохицуулсан нийтлэг үндэслэлийн шинжтэй тусгайлсан зохицуулалт нь тухайн харилцаанд орж буй субъект болгонд ижил үйлчлэлтэй байх асуудлыг тайлбарласан билээ.

Жишээлбэл, иргэний эрх зүйн чадамж, хөөн хэлэлцэх хугацаа, хугацаа тоолох журам, үл хөдлөх эд хөрөнгийн ойлголт, үл хөдлөх эд хөрөнгө үүсэх үндэслэл гэх мэт ойлголтууд нь иргэнд ч, хуулийн этгээдэд ч хамааралтай ба тухайн этгээдийн эрхэлж буй үйл ажиллагааны онцлогоос шалтгаалж, түүний эрх зүйн чадамжийг өөрөөр тогтоох, хөөн хэлэлцэх хугацааг өөрөөр тоолох үндэсгүй юм. Түүнтэй ижил барьцааны эрх, барьцааны гэрээ байгуулах журам, барьцааны эд хөрөнгөөр шаардлага хангах ажиллагаа зэрэг нь иргэний эрх зүйн, тодруулбал эдийн болон эдийн бус баялагийн эрхийн томоохон хэсэг бөгөөд эдгээр зохицуулалт нь үүргийн бусад төрөлд хамаарагдах тохиолдол бүрт тусгайлсан зохицуулалт болдог билээ. Банк зээлийн харилцаанд барьцааны гэрээ байгуулахдаа иргэд хоорондын зээлийн харилцаанаас өөр журмыг баримталдаггүй юм. Үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан тухайн харилцаанд тавих шаардлагыг илүүтэй тодорхой болгох боломжтой хэдий ч Иргэний хуульд заасан хэм хэмжээтэй нийцэх учиртай юм.

Үл хөдлөх эд хөрөнгийг худалдах журмыг Иргэний хуульд заасан тохиолдолд барьцааны гэрээний харилцаанд орсон аливаа субъект энэ журмын дагуу үйл ажиллагаа явуулах нь тусгайлсан зохицуулалтын тухай хууль хэрэглээний дээрх зарчимд тулгуурлаж байгаагаас гадна Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т өөрт нь "энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ" гэж зориудаар тодотгосон заалтад үндэслэгдэнэ. Ийм тодотгол байгаагүй ч үйлчлэх учиртай хууль хэрэглээний зарчмыг, мөн хуульд өөрт нь заасан императив шинжтэй хэм хэмжээг зөрчин байж банк, банк бус санхүүгийн байгууллагын хувьд барьцааны үл хөдлөх эд хөрөнгийг худалдах өөр журам тогтоосныг зөвхөн тухайн субъектын эрх зүйн байдлаар тайлбарлах нь хэтэрхий гэнэн зүйл юм.

Улс орныг батлан хамгаалах онцгой үүрэг бүхий этгээдийн хувьд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдгийг Иргэний хуульд зааснаас өөрөөр тайлбарлах, эрүүл мэндийн байгууллагын хувьд эрүүл мэндэд учирсан хохирол гэдгийг өөрөөр, барилгын байгууллагад бусдын газар дээр барилга, байгууламж барих эрхийг өөрөөр зохицуулахгүй гэдэгт эргэлзээ төрөхгүй байна.

Аливаа ижил төрлийн харилцааг зохицуулсан хэм хэмжээ нь хэн нэгэнд давуу эрх олгох, эсхүл эрхийг хязгаарласан агуулгатай байх учиргүй гэсэн үүднээс Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан "хүн бүр хуулийн... өмнө эрх тэгш байна" гэсэн зарчмыг зөрчсөн гэж Улсын Дээд шүүх үзсэн болно.

3.Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т заасан зохицуулалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн

14. Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан зарчмуудыг зөрчөөгүй гэж үзэхдээ Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч бүртгэлийн байгууллагыг шүүхийн чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага биш гэж тодорхойлсонтой санал нэг байна. Гагцхүү хуулийн тухайн зохицуулалтаар энэ байдал хэрхэн тодорхойлогдож байгааг анхааралтай авч үзэх нь чухал юм.

Барьцааны эрх нь Иргэний хуулийн 87 дугаар зүйлд зааснаар барьцаагаар хангагдаж буй шаардлагын эрхээс салгаж үл болох эрх юм. Тийм ч учраас үндсэн үүргийн дагуу шаардах эрх байгаа эсэх, энэхүү үүргийн хэмжээ ямар байгааг эхлээд тогтоосны эцэст ямар хэмжээний үүргийг барьцааны зүйлийн үнээс гаргуулах вэ гэдгийг шүүх шийдвэрлэдэг. Барьцааны гэрээ байгуулагдсан л бол үндсэн үүргийн хүчин төгөлдөр байдал, түүний хэмжээ хамаагүй гэж үзэх боломжгүй юм. Барьцааны гэрээний өөрийнх нь хүчин төгөлдөр байдлыг ч шүүх тогтоосны эцэст барьцааны зүйлээс шаардлагыг хангуулах эсэхийг шийдвэрлэдэг.

Бүртгэлийн байгууллага энэ байдлыг тодорхойлох эрхгүй бөгөөд үүрэггүй билээ. Тийм ч учраас барьцааны зүйл болох эд хөрөнгийг худалдан борлуулахад үүрэг гүйцэтгүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллага шүүхэд ч, бүртгэлийн байгууллагад ч хандах эрхтэйгээр хуульд тусгасныг Үндсэн хуулийн "шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэсэн зарчмыг зөрчсөн гэж Улсын Дээд шүүх үзсэн юм.

Бүртгэлийн байгууллага нь хууль ёсны ч, хууль бус ч шаардлагын дагуу барьцааны үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах ажиллагааг явуулахгүй байх. Энэ талаар зайлшгүй дүгнэлт хийх нь ойлгомжтой. Бүртгэлийн байгууллагын эрх зүйн талаар хийх дүгнэлтийн цар хүрээ нь шүүхийн эрх мэдлийн асуудал мөн гэдэгт гол анхаарлаа хандуулах нь чухал.

Нөгөө талаар, "шүүхийн бус журмаар ипотекийн зүйлийг борлуулах ажиллагаанд оролцогч талууд ямар ч маргаангүй байх учиртай" эс тэгвээс шүүхэд хандах эрх нь нээлттэй гэж тайлбарт дурдагдсан байна.

Үүргийн харилцааны оролцогч талууд болон барьцааны гэрээний оролцогч талууд үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулах талаар ямар ч маргаангүй бол үүрэг гүйцэтгүүлэгч нь шүүхэд ч, бүртгэлийн байгууллагад ч хандах шаардлага байхгүй юм. Учир нь Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.1-д "ипотекийн шаардлагыг хангах хугацааг үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах эрхтэй" гэж заасан нь үүрэг гүйцэтгүүлэгч банк нь өмчлөгчид шаардлага тавьж, тэрээр энэ шаардлагыг хүлээн зөвшөөрсөн /маргаангүй/ тохиолдолд шүүхийн ч, бүртгэлийн ч оролцоогүйгээр үл хөдлөх эд хөрөнгийн худалдах-худалдан авах гэрээгээр асуудлыг зохицуулах боломжтой юм. Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд шүүхийн шийдвэрийн дагуу албадан дуудлага худалдаа явуулна гэж хуулийн 175 дугаар зүйлийн 175.1-д заажээ.

Шүүхийн бус журмаар үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулсан ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах нь нээлттэй гэж тайлбарт дурджээ. Оролцогч талуудын шүүхэд хандах эрхийг бүрмөсөн хаагаагүй нь үнэн. Гэхдээ Иргэний хуулийн энэ заалт Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэхдээ Улсын Дээд шүүх тухайн харилцаанаас үүсэх сөрөг үр дагавар талаас нь биш харин хуулийн зохицуулалт сөрөг үр дагаврыг үүсгэх боломж бүрдүүлж байгаа талаас нь асуудлыг дэлгэсэн юм.

Монгол Улсын иргэний өмчид төр л хуульд заасан үндэслэлийн дагуу халдах эрхтэй ба энэ тохиолдолд ч нөхөн төлбөр олгох үүрэгтэй байдаг. Тэгвэл төр өөрийн баталж буй хуулиар төрийн хяналтад байдаггүй субъект болох банкинд бусдын өмчлөлд халдах эрхийг олгож буй нь Үндсэн хуулийг зөрчсөн явдал гэж үзэж байна. Банк үндсэндээ багахан хэмжээний төлбөртэй байсан ч бусдын үл хөдлөх эд хөрөнгийг шууд, чөлөөтэй бөгөөд зөвхөн өөрийн төлбөрөө гаргуулах төдий үнээр буюу бодит үнээс доогуур худалдах боломжтой болно. Банк үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөтэй худалдах эрхтэй байгаа тохиолдолд зах зээлийн бодит үнээр зарагдах баталгаа байхгүй юм.

Аливаа шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг төр эсвэл дор хаяж төрөөс эрх олгогдсон ямар нэгэн байгууллага шүүхийн шийдвэрийн үндсэн дээр гүйцэтгэдэг ба үл хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрөө худалдан борлуулах боломжтой болгосноор Үндсэн хуульд тусгагдсан өмчлөх эрхийн баталгааг тойрч гарч байгаа арга гэж үзэх ч үндэстэй юм" гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-т "Барьцааны зүйл нь бусдын

өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэжээ.

Үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд хөрөнгөө шилжүүлэхгүйгээр өөрийн өмчлөлийн зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангаад үлдсэн хэсэгтээ өөрөө өмчлөгч хэвээр үлдэх, үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс үүргийг гүйцэтгээд барьцааны үүргээс чөлөөлөгдөж, өмчлөлийн зүйлээ өөрийн өмчлөлд хэвээр хадгалах, барьцааны зүйлийг хариу төлбөртэй буюу төлбөргүйгээр үүрэг гүйцэтгэгч бус өөр гуравдагч этгээдийн өмчлөлд шилжүүлэх замаар барьцааны үүргийг шинэ өмчлөгчид шилжүүлэх зэрэг эрхүүд нь барьцаалуулагчид нээлттэй байдаг. Энэ нь иргэний эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим юм.

Иймд Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь заалтын хоёрдахь өгүүлбэр нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-д заасан "Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх ... эрхтэй" гэснийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

2.Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2-т "Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахад энэ хуульд заасан журмыг баримтлах бөгөөд энэ хуулийн зохицуулалтыг илүү нарийвчилсан зохицуулалт гэж үзнэ.

Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй" гэжээ.

Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол Иргэний хуулиар зохицуулсан барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг худалдах журам огт хамаарахгүй гэж ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол, үүрэг гүйцэтгэгч, эсхүл барьцаалуулагч болох үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч Иргэний хуульд заасан журмын дагуу барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг худалдах, шүүхийн шийдвэрийн дагуу үүргийн гүйцэтгэлийг хангуулах хүсэлт гаргасан ч гэсэн Иргэний хуулийн 175 дугаар зүйлд заасан журмыг баримтлах заалтыг хамаарахгүй гэж хуульчилсан учраас үүрэг гүйцэтгэгч болон үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчийн эрх зөрчигдөхөд хүрч байна.

Иймд Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь заалтын "...Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна..." гэснийг зөрчиж байна гэсэн хүсэлтийг хүлээн авах үндэслэлтэй байна.

3.Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т "...Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй" гэжээ.

Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т зааснаар үүргийн нэг тал болох үүрэг гүйцэтгүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллага дангаараа эрхээ хамгаалуулах этгээдийг өөрийн үзэмжээр сонгохоор зааж, харин үүргийн нөгөө тал болох үүрэг гүйцэтгэгч буюу үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч-барьцаалуулагчид сонгох боломж олгоогүй байгаа ба ийнхүү иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш оролцогч субъектуудын хувьд ялгавартай зохицуулсан нь тэгш эрхийн зарчим зөрчигдсөний зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна...", Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан "...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно", Арван зургадугаар зүйлийн 14-т заасан "...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй...", түүнчлэн талуудын шүүхэд хандах эрхийг нь хязгаарлан бүртгэлийн байгууллагад бүртгүүлж ипотекийн зүйлийг худалдан борлуулахаар заасан нь Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан "...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", мөн Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан "...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

4.Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь заалтын "Барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно", 154.4 дэх заалт "Барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэсэн ийм тохиолдол байж болох бөгөөд хэн нэгний өмчлөх эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

**Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь заалтын "...Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн

өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан "Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх ...эрхтэй" гэснийг; Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь заалтын "...Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэснийг; 174.3 дахь заалт "Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан "...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна", Арван зургадугаар зүйлийн 14-д заасан "...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх ...эрхтэй", Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т заасан "...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно", Дөчин долдугаар зүйлийн 1-д заасан "...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан "...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно" гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь заалтын "Барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно", 154.4 дэх заалт "Барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-д заасан "Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө ...өмчлөх ...эрхтэй" гэснийг зөрчөөгүй байна.

3.Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-ын "...энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ..." гэсэн заалт, 174 дүгээр зүйлийн 174.2-ын "...барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй" гэсэн заалт болон 174 дүгээр зүйлийн 174.3-ын "Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5-175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй" гэсэн заалтын үйлчлэлийг 2006 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар 15 хоногийн дотор хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

| | |
|---|---|
| **ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ** | **Ж.БЯМБАДОРЖ** |
| **ГИШҮҮД** | **Н.ЖАНЦАН**<br>**Л.РЭНЧИН**<br>**П.ОЧИРБАТ**<br>**Д.НАРАНЧИМЭГ** |

## ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны хоёрдугаар сарын 28-ны өдрийн 8 дугаарт нийтлэгдсэн Улсын Их Хурлын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг" -ийн 14.2-ын "52.1.1, 52.1.2-т" гэснийг "51.1.1, 51.1.2-т" гэж залруулан уншина уу.

Мөн "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны хоёрдугаар сарын 14-ний өдрийн 6 дугаарт нийтлэгдсэн "Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн 4 дүгээр зүйлд "22.2-ын" өмнө "21.2-ын "эмнэлгийн төлбөргүй тусламж, үйлчилгээний зардал болон төрийн өмчийн эмнэлгийн байгууллага, өрхийн эмнэлгийн тогтмол" гэснийг "төрөөс хариуцах тусламж, үйлчилгээ нь нэн шаардлагатай тусламж, үйлчилгээнд хамаарах ба эдгээрийн" гэж нэмж залруулан уншина уу.

УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтэс

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

Хэвлэлийн хуудас 5.5

☎ 329487